

## МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хавсралт 5

### НЭГ. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	Засгийн газрын 2018 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр Хөтөлбөрийн зорилго: Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд оршино.
2	Санхүүжилтийн эх үүсвэр	5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ: 5.1.1. улсын төсөв, олон улсын байгууллага, гадаад орны зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт; 5.1.2. гоц халдварт, халдварт, зооноз өвчин дэгдсэн онцгой байдлын үед улсын болон орон нутгийн төсөв; 5.1.3. төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж; 5.1.4. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Мал эмнэлгийн ерөнхий газар- 4 жил, 2018-2021 он Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, МЭЭСБУЛ, УМЭАЦТЛ, Биокомбинат
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 2.2.1: мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох Зорилт 2.2.2: мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах; Зорилт 2.2.3: мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах; Зорилт 2.2.4: мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох; Зорилт 2.2.5: мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх; Зорилт 2.2.6: малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах.
5	Зардал	Төсөв (Нийт зардал) <span style="float: right;">Улсын төсвийн 35,6 тэрбум төгрөг</span>
	Үүнд:	Төсөв (2019 он) <span style="float: right;">Гүйцэтгэл</span> <span style="float: right;">Хувь</span>
	Бүрэлдэхүүн хэсэг 1	-

	Бүрэлдэхүүн хэсэг 2	33,800.00	30,480.00	90.2					
	Бүрэлдэхүүн хэсэг 3	1,380.00	1,350.00	97.8					
	Бүрэлдэхүүн хэсэг 4	-	-	-					
	Бүрэлдэхүүн хэсэг 5	92.6	92.3	99.7					
	Бүрэлдэхүүн хэсэг 6	337.30	299.00	88.6					
	Удирдлага								
	<b>Нийт</b>	<b>35,609.9</b>	<b>32,221.30</b>	<b>90.5</b>					
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ							
	1-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 118-124 дугаар хуудас.							
	2-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 124-132 дүгээр хуудас.							
	3-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 132-140 дугаар хуудас.							
	4-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 140-144 дүгээр хуудас.							
	5-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 144-149 дүгээр хуудас.							
	6-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 149-152 дугаар хуудас.							
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Дүгнэлт.</p> <p>1.Хөтөлбөрийн төлөвлөгөөнд нийт 99 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас 2019 оны хэрэгжилтийн үнэлгээ 84.6 хувь, хөтөлбөрийн явцын хэрэгжилт 78.1 хувьтай байна.</p> <p>2.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш нэг жил хагасын хугацаа өнгөрсөн хэдий ч дагалдан гарах эрх зүйн баримт бичгийн боловсруулалт хангалтгүй байгаа нь тус хөтөлбөрийн үнэлгээнд сөргөөр нөлөөлж байна.</p> <p>Зөвлөмж.</p> <p>1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А-11 дүгээр тушаалаар баталсан “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний холбогдох заалт, арга хэмжээ хариуцсан мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан эсэхийг хянаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах,</p> <p>2.Төлөвлөгөөний 72, 73, 74 дугаартай арга хэмжээ нь МХЕГ-ын чиг үүрэгт хамаарах тул төлөвлөгөөнөөс хасч батлуулахыг МЭЕГ-т,</p> <p>3.Төлөвлөгөөний холбогдох заалт, арга хэмжээг хариуцсан мэргэжилтэн бүрэн хэмжээнд тайлагнасан эсэх, хангалттай үнэлгээ авсан эсэхийг харгалзан гүйцэтгэлийн төлөвлөгөөний тус зорилтын биелэлтийг дүгнэж хэвших,</p> <p>Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль түүнийг дагалдан гарах эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах болон Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний эзэнжүүлсэн төлөвлөгөөг МЭЕГ-ын даргаар батлуулах, төлөвлөгөөний хэрэгжилтэд сар, улирал тутам хяналт тавьж ажиллах зэрэг болно.</p>							
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хангалттай бус							
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ) Төсөл хэрэгжиж эхэлснээс хойших үнэлгээгээр	Биелэлт дундаж	Зорилт ын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт 6
		78.1	6	80.2	77.0	79.4	65.6	83.9	100.0
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ			... %				

**ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА.**

Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.32 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр батлах тухай 12 дугаар тогтоолоор, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А-11 дүгээр тушаалаар “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус баталсан.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.**

Арга хэмжээний гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан тогтоож, тэдгээрийн хоорондын зөрүүг илрүүлэн дүн шинжилгээ хийж шалтгааныг тодруулах, түүнд үндэслэн зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.**

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2019 оны жилийн эцсийн тайланг судлах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтантай ярилцах, холбогдох газраас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

**Хөтөлбөрийн зорилго.** Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд оршино.

**Хөтөлбөрийн зорилт.**

1. Мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах;
3. Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах;
4. Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох;
5. Мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;
6. Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах.

**Хүлээгдэж буй үр дүн**

- Зорилт 1. Нийт 92 журам, заавар батлуулсан байна.
- Зорилт 2. Халдварт өвчингүй статустай газар нутгийн хэмжээг 10 хувьд хүргэх.
- Зорилт 3. Гоц халдварт өвчний вакцинжуулалт хийж байгаа аймгийн тоо шүлхий -3, бог малын мялзан -0, хонь, ямааны цэцэг-0 болгох.
- Зорилт 4. Мал эмнэлгийн хяналтын цэгээр дамжин өнгөрсөн мал, тээврийн хэрэгслийн тоо буурах.
- Зорилт 5. Сургалтад хамрагдсан малын эмч, мэргэжилтний тоо 2700-д хүргэх.
- Зорилт 6. Сургалтад хамруулсан малчин, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн тоог 35000-д хүргэх.

Хэрэгжих хугацаа. Хөтөлбөр нь 2018-2021 онд буюу 4 жилийн хугацаанд хэрэгжинэ.

**ХӨТӨЛБӨРИЙН 2019 ОНЫ ХЭРЭГЖИЛТ.** Хөтөлбөрийн төлөвлөгөөнд нийт 99 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас 2019 оны хэрэгжилтийн үнэлгээ 84.6 хувь, үндэсний хөтөлбөрийн явцын хэрэгжилт 78.1 хувьтай байна. Үүнд:

100 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	59
70 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	17
40 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	11
0 үнэлгээтэй арга хэмжээ	3
Хэрэгжилтийн хугацаа болоогүй арга хэмжээ	9 тус тус байна.

**ЗОРИЛТ 1. МАЛ ЭМНЭЛГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ;**

Тус зорилтын 2019 оны хүрэх түвшингийн биелэлт 78.6 хувь, зорилтын явцын хэрэгжилт 80.2 хувь тус тус байна. Үүнд: Төлөвлөгөөнд нийт 29 арга хэмжээ тусгаснаас

0 үнэлгээтэй	2
40 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	3
70 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	8
100 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	16 тус тус байна.

**ЗОРИЛТ 2. МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ БОЛОН ХАЛДВАРТ, ШИНЭ БОЛОН ДАХИН СЭРГЭЖ БАЙГАА ӨВЧНИЙГ ЭРТ ИЛРҮҮЛЭХ ТАНДАЛТЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЗАМААР ӨВЧНИЙГ ХЯНАЛТАД АВЧ, ХАЛДВАРТ ӨВЧИНГҮЙ ТАЙВАН БАЙДЛЫГ ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ ХАРГАЛЗАН БҮС НУТГААР БАТАЛГААЖУУЛАХ;**

Тус зорилтын 2019 оны хүрэх түвшингийн биелэлт 90.6 хувь, зорилтын явцын хэрэгжилт 77.0 хувь тус тус байна. Үүнд: Төлөвлөгөөнд нийт 19 арга хэмжээ тусгаснаас

40 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	1
70 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	3
100 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	12
Хэрэгжилтийн хугацаа болоогүй арга хэмжээ	3,

**ЗОРИЛТ 3. МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ, ЗООНОЗ, ШИНЭ БОЛОН ДАХИН СЭРГЭЖ БАЙГАА ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ШИНЖЛЭХ УХААНЫ НОТОЛГОО, ТАРХВАР ЗҮЙН СУДАЛГААГ ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨХ ЗАМААР БҮС НУТГААР НЬ ХЯНАЛТАД АВАХ;**

Тус зорилтын 2019 оны хүрэх түвшингийн биелэлт 88.8 хувь, зорилтын явцын хэрэгжилт 79.4 хувь тус тус байна. Үүнд: Төлөвлөгөөнд нийт 20 арга хэмжээ тусгаснаас

40 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	2
70 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	2
100 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	12
Хэрэгжилтийн хугацаа болоогүй арга хэмжээ	4,

**ЗОРИЛТ 4. МАЛ, АМЬТНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧИН ГАРАХ, ТАРХАХ ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХ;**

Тус зорилтын 2019 оны хүрэх түвшингийн биелэлт 65.6 хувь, зорилтын явцын хэрэгжилт 65.6 хувь тус тус байна. Үүнд: Төлөвлөгөөнд нийт 9 арга хэмжээ тусгаснаас

0 үнэлгээтэй арга хэмжээ	1
40 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	3
70 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	1
100 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	4

**ЗОРИЛТ 5. МАЛ ЭМНЭЛГИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭРГЭЖИЛТЭН, МАЛЫН ЭМЧ НАРЫН МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, МАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ;**

Тус зорилтын 2019 оны хүрэх түвшингийн биелэлт 83.9 хувь, зорилтын явцын хэрэгжилт 83.9 хувь тус тус байна. Үүнд: Төлөвлөгөөнд нийт 14 арга хэмжээ тусгаснаас

40 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	2
70 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	3

100 хувийн үнэлгээтэй арга хэмжээ	8
Хэрэгжилтийн хугацаа болоогүй арга хэмжээ	1

**ЗОРИЛТ 6. МАЛЧИН, ҮЙЛДВЭРЛЭГЧ, ХЭРЭГЛЭГЧДИЙГ МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНД, ТҮҮНТЭЙ ШУУД ХОЛБОГДОХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАЖ, ҮР ДҮНГ СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ.**

Тус зорилтын 2019 оны хүрэх түвшингийн биелэлт 100.0 хувь, зорилтын явцын хэрэгжилт 100.0 хувь тус тус байна. Үүнд: Төлөвлөгөөнд нийт 8 арга хэмжээ тусгаснаас 100 хувийн үнэлгээтэй арга хэмжээ 7  
Хэрэгжилтийн хугацаа болоогүй арга хэмжээ 1 тус тус байна.

#### ДҮГНЭЛТ

1. Хөтөлбөрийн төлөвлөгөөнд нийт 99 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас 2019 оны хэрэгжилтийн үнэлгээ 84.6 хувь, хөтөлбөрийн явцын хэрэгжилт 78.1 хувьтай байна.

2. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш нэг жил хагасын хугацаа өнгөрсөн хэдий ч дагалдан гарах эрх зүйн баримт бичгийн боловсруулалт хангалтгүй байгаа нь тус хөтөлбөрийн үнэлгээнд сөргөөр нөлөөлж байна.

#### ЗӨВЛӨМЖ.

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А-11 дүгээр тушаалаар баталсан “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний холбогдох заалт, арга хэмжээ хариуцсан мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан эсэхийг хянаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах,

2. Төлөвлөгөөний 72 (3.4.3.1), 73 (3.4.3.2), 74 (3.4.3.3) дугаартай арга хэмжээ нь МХЕГ-ын чиг үүрэгт хамаарах тул төлөвлөгөөнөөс хасч батлуулахыг МЭЕГ-т,

3. Төлөвлөгөөний холбогдох заалт, арга хэмжээг хариуцсан мэргэжилтэн бүрэн хэмжээнд тайлагнасан эсэх, хангалттай үнэлгээ авсан эсэхийг харгалзан гүйцэтгэлийн төлөвлөгөөний тус зорилтын биелэлтийг дүгнэж хэвших,

4. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль түүнийг дагалдан гарах эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах болон Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний эзэнжүүлсэн төлөвлөгөөг МЭЕГ-ын даргаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтэд сар, улирал тутам хяналт тавьж ажиллах зэрэг болно.

**МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**  
2019 оны жилийн эцэс

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2019 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэл -гээ
3.1.1. Мал, амьтны гоц халдварт, зооноз, халдварт өвчинтэй тэмцэх төлөвлөгөө (2018-2022)-г шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх;						
1	3.1.1.1. Шүлхий өвчинтэй тэмцэх төлөвлөгөө боловсруулж батлуулах;	2019			Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн А/62 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгийн 4 удаагийн хурлаар төслийг хэлэлцэн эцэслэсэн. ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлуулахаар стратегийн төслийн эцсийн боловсруулалт хийж байна.	40%
2	3.1.1.2. Хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг боловсруулж, батлуулах;	2019			Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/58 дугаар тушаалын хавсралтаар "Хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар"-ыг баталж, хууль эрх зүйн мэдээллийн санд бүртгүүлсэн. Линк. <a href="https://www.legalinfo.mn/law/details/13966">https://www.legalinfo.mn/law/details/13966</a>	100%
3	3.1.1.3. Бог малын мялзан өвчинтэй тэмцэх төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах;	2019			Бог малын мялзан өвчинтэй тэмцэх хөтөлбөрийн төслийг 2016 онд төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр боловсруулж, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, ХХААХҮ-ийн сайдаар батлуулахад бэлэн болгоод байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/04 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан. <a href="https://www.legalinfo.mn/annex/?lawid=14189">https://www.legalinfo.mn/annex/?lawid=14189</a>	70%
4	3.1.1.4. Бруцеллэз өвчинтэй тэмцэх төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах;	2019			Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А-154 дүгээр тушаалаар баталсан "Малын бруцеллэзтой тэмцэх стратеги, төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд ХХААХҮ-тай хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна. Мөн ХХААХҮ-ийн сайдын тушаалаар тус стратеги, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.	40%
5	3.1.1.5. Дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж батлуулах	2019			Монгол улсын Шадар сайдын 2018 оны 08 дугаар тушаалаар баталсан "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний календарьчилсан төлөвлөгөө"-г 2019 онд баримтлан ажилласан. Шүлхий өвчний эрсдэлтэй нийт 9 аймгийн 118 суманд 2 удаагийн давталттайгаар нийт 22.7 сая толгой малыг дархлаажуулалтад хамруулж, 3.5 тэрбум төгрөг, Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад зүүн бүсийн 5 аймгийн 57 сумын нийт 5.8 сая толгой мал хамруулж, 796.5 сая төгрөг, Хонины цэцгээс сэргийлэх дархлаажуулалтад зүүн бүсийн 5 аймгийн 62 сумын нийт 2.9 сая толгой хонь, хурга хамруулж, 427.1 сая төгрөгийн санхүүжилтийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгосон. 2019 оны жилийн эцсийн байдлаар гоц халдварт өвчний хорио цээртэй аймаг, сум байхгүй ба гоц халдварт өвчний гаралтыг 2018 оны 06 дугаар сартай харьцуулахад шүлхий 90, бог малын мялзан 80 хувиар буурсан бол	100%

					хонины цэцгийн гаралт буураагүй байна. Монгол улсад нийт 18 нэрийн халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 22.5, бруцеллэз өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 15.2, нийт халдварт, гоц халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 60.4 сая толгой мал хамруулсан. Яаралтай дархлаажуулалтын төлөвлөгөөг МЭЭГ-ын даргын 2020 оны 02-р сарын 18-ны өдрийн А/34 дугаартай тушаалын хавсралтаар баталгаажуулан хэрэгжүүлж байна. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын төлөвлөгөөний төслийг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын дэргэдэх Мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн А/43 дугаар тушаалаар батлуулан, тушаалыг Биокомбинат УТҮГ, МЭЭСБУЛ УТҮГ, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэн хэрэгжүүлж ажиллаж байна.	
6	3.1.1.6. Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын улсын төлөвлөгөөг боловсруулж батлуулах;	2019			НҮБ-ын ХХААБ-ын дэмжлэгтэйгээр төслийг боловсруулсан бөгөөд ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлуулахаар бэлтгэж байна.	40%
7	3.1.1.7. Зооноз өвчнийг хяналтад авах хяналтад авах стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах;	2019			Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн дагуу "Зооноз өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах хамтарсан зөвлөлийн ажиллах журам"-ыг Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А-449, А/544 дугаар хамтарсан тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. Эрүүл мэндийн яамтай харилцан тохирсны үндсэн дээр тус журмын хүрээнд Зооноз өвчнийг хяналтад авах стратеги, төлөвлөгөөг боловсруулж, төслийг ЭМЯ-нд хүргүүлсэн. Хорио цээрийн арга хэмжээ тавигдмагц эхний хурлыг хийхээр бэлтгэл ажлыг хангаад байна.	70%
3.1.2. Мал эмнэлэг, ариун цэвэр, оношилгооны лабораториудыг сүлжээгээр ажиллах журам, бүсчлэн хөгжүүлэх чиглэлийг шинээр боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх;						
8	3.1.2.1. Улсын мал эмнэлгийн лаборатори болон Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторид эцсийн онош тогтоох мал, амьтны халдварт өвчний жагсаалтыг боловсруулж батлуулах;	2019 - 2020			"Улс, аймаг, нийслэл, сумын түвшинд мал эмнэлгийн лабораторийн шинжилгээ хийх өвчний жагсаалтын төслийг 2019 оны 04 сарын 01-ний өдөр УМЭАЦТЛ-ийн эмч нарын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн эцэслэж, Мал эмнэлгийн ерөнхий газарт ирүүлснээр 4 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж эцэслэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын тушаал батлуулах бэлтгэл хангаж байна.	70%
9	3.1.2.2. Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журмыг боловсруулж батлуулах;	2019 - 2020			Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт Аймаг, нийслэл, сум, дүүргийн мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам, Мал эмнэлгийн үндэсний лавлагаа лабораторийг сонгох журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын болон Мал эмнэлэг, үржлийн газрын даргын 2017 оны шийдвэрээр журам, заавар, эрхзүйн баримт бичиг боловсруулж, батлуулах ажлын хэсэг	70%

					томилогдож, тус журмын төслийн 5 удаагийн хэлэлцүүлгийг хийж, ХХААХҮЯ-ны цахим хуудсанд байршуулан санал авсан. Мал эмнэлгийн ерөнхий газарт ирүүлсэн төслийг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, эцэслэн батлуулахаар ажиллаж байна.	
10	3.1.2.3. Мал эмнэлгийн үндэсний лавлагаа лабораторийг сонгох журмыг боловсруулж батлуулах;	2019 - 2020			Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт Аймаг, нийслэл, сум, дүүргийн мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам, Мал эмнэлгийн үндэсний лавлагаа лабораторийг сонгох журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын болон Мал эмнэлэг, үржлийн газрын даргын 2017 оны шийдвэрээр баталсан журам, заавар, эрхзүйн баримт бичиг боловсруулж, батлуулах ажлын хэсэг томилогдож, тус журмын төслийн 5 удаагийн хэлэлцүүлэг хийж, ХХААХҮЯ-ны цахим хуудсанд байршуулан санал авсан. Мал эмнэлгийн ерөнхий газарт ирүүлсэн төслийг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж эцэслэн батлуулахаар ажиллаж байна.	70%
11	3.1.2.4. Мал эмнэлгийн лабораторийг хөгжүүлэх стратегийн баримт бичгийг боловсруулж батлуулах;	2019 - 2020			Аймаг, нийслэл, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн лабораторийг хөгжүүлэх, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор ойрын таван жилийн хугацаанд болон 2030 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн, тавьсан зорилгыг тодорхойлсон “Мал эмнэлгийн хоёрдугаар шатлалын лабораторийг хөгжүүлэх дунд болон урт хугацааны стратеги”-ийг боловсруулан 2020 онд батлуулахаар бэлтгэж байна. Мал эмнэлгийн бүх шатны лабораторид хөрөнгө оруулалт хийх, төрөл бүрийн хэлбэрээр дэмжлэг үзүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, үйл ажиллагааны жилийн төлөвлөлт хийхэд энэхүү стратегийг үндэслэл болгоно.	0%
3.1.3. Мал, амьтны гоц халдварт, зооноз, халдварт болон паразиттах өвчинтэй тэмцэх зааврыг шинэчлэн өвчний тохиолдол, оношилгоо, хариу арга хэмжээнд баримтлах зааваруудыг өвчин тус бүрээр боловсруулж батлуулан мөрдүүлэх;						
12	3.1.3.1. Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	2018 - 2019			Мал, амьтны гоц халдварт шүлхий, хонины цэцэг, шувууны томуу, боом, галзуу гэх мэт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх 14 зааврыг боловсруулан, МЭЕГ-ын даргаар батлуулж, ХЗДХЯ-аар хянуулж, хууль эрх зүйн мэдээллийн санд бүртгүүлэх ажил хийгдэж байна.	100%
13	3.1.3.2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	2018 - 2019			Мал, амьтны халдварт цусан халдвар, дотрын халдварт хордлого гэх мэт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх 43 заавар боловсруулан, МЭЕГ-ын даргаар батлуулж, ХЗДХЯ-аар хянуулж, хууль эрх зүйн мэдээллийн санд байршуулаад байна.	100%
14	3.1.3.3. Малаас хүнд дамжин халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	2018 - 2019			Мал, амьтны сүрьеэ, бруцеллөз, галзуу, боом гэх мэт зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг боловсруулан, МЭЕГ-ын даргаар батлуулж, ХЗДХЯ-аар хянуулж, хууль эрх зүйн мэдээллийн санд байршуулан, мөрдлөг болгон ажиллаж байна.	100%



15	3.1.3.4. Шимэгчтэх өвчинтэй тэмцэх стандарт ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	2018 - 2019			Мал, амьтны шимэгчтэх эргүү, бэтэг, бабезиоз гэх мэт шимэгчтэх өвчнөөс сэргийлэх, тэмцэх 14 зааврыг боловсруулан, МЭЕГ-ын даргаар батлуулж, ХЗДХЯ-аар хянуулж албан ёсны сайтад байршуулан, мөрдлөг болгон ажиллаж байна.	100%
3.1.4. Малын шилжилт хөдөлгөөн, мал аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүнд тавигдах дотоодын стандарт, чанар, аюулгүй байдлын шаардлага, журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх;						
16	3.1.4.1. Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам болон мах бэлтгэл, отор, нүүдлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэл;	2018 - 2019			Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам”, “Отор, нүүдлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэл”, “Мах бэлтгэлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэл”-ийг тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мал, амьтны гоц халдварт өвчин дамжин тархахаас урьдчилан сэргийлэн, нийтийн эрүүл мэндийг хамгаалан байнгын ажиллагаатай Архангай аймгийн Цахир сумын Солонготын давааны ам, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Гуртын гүүр, Төв аймгийн Лүн сумын Гүүрний ам, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Таацын голын гүүр, СХД-ийн Шар хөтөл, Багануур дүүргийн Хэрлэнгийн гүүр, ХУД-ийн Өлзийт хорооллын уулзвар, Таван толгойн уулзварын мал эмнэлгийн хяналтын цэгт мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн гэрчилгээний баталгаажилтад хяналт, шалгалт хийх удирдамжийн дагуу хяналт, шалгалт тогтмол хийж байна. Мал эмнэлгийн хяналтын цэгүүдэд 29195 авто тээврийн хэрэгсэл хяналт шалгалтад хамрагдсан.	100%
17	3.1.4.2. Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт, дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоолоор “Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт” болон “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг батлуулсан. <a href="https://www.legalinfo.mn/law/details/13648">https://www.legalinfo.mn/law/details/13648</a>	100%
18	3.1.4.3. Мал амьтныг нүүлгэн шилжүүлэх журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Мал, амьтныг нүүлгэн шилжүүлэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална” гэж заасны дагуу Мал, амьтныг нүүлгэн шилжүүлэх журмыг МЭЕГ-ын даргын тушаалаар батлуулан Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.	100%
19	3.1.4.4. Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх зааврыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			Мал эмнэлгийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгож олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн Ерөнхий газраас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны хүрээнд мал эмнэлгийн салбарт хууль эрх зүйн шинэ орчныг боловсронгуй болгох зорилгоор Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хүүрэнд “Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар”-ийг Мал	100%

					эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар батлуулан ХЗДХЯ-нд танилцуулан, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан 4156 дугаарт бүртгүүлж, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны 95 дугаар тоот албан бичгээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газруудад хүргүүлж 332 сум, 6 дүүргийн мал эмнэлгийн тасгийн эмч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт танилцуулав.	
20	3.1.4.5. Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг хорио цээрийн журам, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасан Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг, хорио цээрийн журмыг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/08 дугаар тушаалаар, "Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журам", "Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийн загвар", "Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийн (код) индексийн дугаар"-ыг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/234 дүгээр тушаалаар тус тус батлуулж Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу Хууль зүйн яаманд бүртгүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. "Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журам"-ын дагуу сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 987 гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид баталгааны тэмдэг олгоод байна. Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг хорио цээрийн журмыг хэрэгжүүлэх зорилгоор МЭЕГ-ын даргын тушаалаар мал төхөөрөх 68 үйлдвэрт мал эмнэлгийн улсын байцаагчийг томилон журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Мөн журмын хэрэгжилтийг хангах зорилгоор МЭЕГ-ын тушаалаар "Хүнсний зориулалтаар мал бэлтгэх, тээвэрлэх, тууварлах, үйлдвэрт хүлээн авах, төхөөрөх үед мал эмнэлэг-ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийх, үнэлэх стандарт ажиллагааны түр заавар" батлуулан Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу Хууль зүйн яаманд бүртгүүлэх ажил хийгдэж байна.	100%
21	3.1.4.6. Мал, эмнэлэг, ариун цэврийн шаардлагыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасан "Хот суурин газрын нутаг дэвсгэрт мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний бус түүхий эдийн худалдаа эрхлэхэд тавигдах мал эмнэлэг, ариун цэврийн шаардлага"-ыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлуулж, Захиргааны хуульд заасны дагуу Хууль зүйн яаманд бүртгүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
22	3.1.4.7. Жороор олгох мал, амьтны эмийн жагсаалт, журмыг боловсруулан батлуулах;	2018 - 2019			Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 24.1 "Жороор олгох мал, амьтны эмийн жагсаалт, журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална" заалтыг хэрэгжүүлэхээр МЭЕГ-ын даргын	70%

					тушаалаар ажлын хэсэг байгуулагдан, Жороор олгох мал, амьтны эмийн жагсаалт, журмын төслийг боловсруулан 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2020 оны эхний хагаст багтаж батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. "Мал, амьтны эм, гэжээлийн нэмэлтийн нэгдсэн бүртгэл мэдээллийн цахим сан"-гийн сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна. тус цахим санд жороор олгох эмийн мэдээллийг шинэчлэн оруулахаар бэлтгэл ажил хийгдэж байна	
23	3.1.4.8. Түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох зааврыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			Мал эмнэлгийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгож олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн Ерөнхий газраас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны хүрээнд "Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар"-ийг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/51 дугаар тушаалаар батлуулан ХЗДХЯ-нд танилцуулан, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан 4156 дугаарт бүртгүүлж, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны 95 тоот албан бичгээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газруудад хүргүүлж 332 сум, 6 дүүргийн мал эмнэлгийн тасгийн эмч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт танилцуулав.	100%
24	3.1.4.9. Магадлан шинжилгээний мал эмнэлгийн гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох зааврыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			Мал эмнэлгийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгож олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн Ерөнхий газраас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны хүрээнд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хүрээнд "Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар"-ыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/46 дугаар тушаалаар батлуулан аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрууд болон 332 сум, 6 дүүргийн мал эмнэлгийн тасгийн эмч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт танилцуулж, мөрдөж байна..	100%
25	3.1.4.10. Үйлдвэр, цехэд түүхий сүү нийлүүлэх, худалдах үед мөрдөх ариун цэвэр, эрүүл ахуйн зааврыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			МЭЭГ-ын даргын 2019 оны А/08 дугаар тушаалаар "Үйлдвэр, цехэд түүхий сүү нийлүүлэх, худалдах үед мөрдөх эрүүл ахуй, ариун цэврийн заавар"-ыг нэгдүгээр, Хот суурин газрын нутаг дэвсгэрт мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний бус түүхий эдийн худалдаа эрхлэхэд тавигдах мал эмнэлэг, ариун цэврийн шаардлага"-ыг батлуулж Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хууль зүйн яаманд 4207-д бүртгүүлж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.	100%
3.1.5. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд мөрдөх журам, стандартуудыг боловсруулж мөрдүүлэх.						
26	3.1.5.1. Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмыг шинэчлэн	2018 - 2020			Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.18 дахь хэсэгт "Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" заасны дагуу журмын	100%

	боловсруулан батлуулах;				төслийг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/457 дугаар тушаалаар батлуулж Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу Хууль зүйн яаманд 2019-12-20-ны өдөр 4560 дугаарт бүртгүүлж хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	
27	3.1.5.2. Төгсөлтийн дараахь үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2020			Төгсөлтийн дараахь үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журмыг МЭЕГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг боловсруулан ХХААХҮ-ийн Сайдын 2018 оны 10 сарын 22-ны өдрийн А-178 дугаар тушаалаар батлуулсан. Тус журмыг Хууль зүйн яаманд хүргүүлж хянуулсан боловч зарим нэр томъёоны асуудлыг тодруулах шаардлагатай гэдэг асуудлаар буцаагдаж, шинэчлэн боловсруулалт хийж, ХХААХҮ-ийн сайдаар батлуулах бэлтгэл хангаж байна.	70%
28	3.1.5.3. Малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2020			Мал эмнэлгийн салбарт ажиллаж байгаа малын эмчийн малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, түүнийг баталгаажуулж хяналт тавихтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах мэргэжлийн зэрэг олгох журмын төсөл боловсруулах шатандаа явагдаж байна.	0%
29	3.1.5.4. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг шинээр боловсруулан батлуулах;	2018 - 2020			Мал эмнэлгийн ерөнхий газраас 2019 онд Мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг шинээр боловсруулан, батлуулахаар зөвлөх үйлчилгээний тендерийг зарлан Хувийн мал эмнэлгийн нэгжийн дундын хоршоо ТББ шалгаран ажлын даалгаврын дагуу боловсруулан хүлээлгэн өгсөн. Гэвч ХХААХҮЯ, Сангийн яамнаас тус ажлыг дахин боловсруулах чиглэлийг өгсөний дагуу 2020 онд дахин эдийн засгийн баг ажиллуулахаар төлөвлөн ажил гүйцэтгэх тендер зарлаад байна. 2020 оны 3 дугаар сард багтаан Сангийн яаманд хүргүүлж, Сангийн сайд, ХХААХҮ-ийн сайдаар батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.	70%
<b>3.2.1. Мал эмнэлгийн салбарын мэдээллийн нэгдсэн цахим сүлжээг бий болгох;</b>						
30	3.2.1.1. Мал, амьтны гоц халдварт, шинэ болон дахин сэргэж буй өвчний мэдээллийн сан бий болгон ажиллуулах;	2019			Мал эмнэлгийн ерөнхий газар, Швейцарын элчин сайдын яамны хамтын ажиллагааны газартай байгуулсан гэрээний хүрээнд Ногоон алт-Малын эрүүл мэнд төсөл, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/167 дугаар тушаал болон малын эрүүл мэндийн нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлыг 21 аймаг, нийслэлд зохион байгуулж нэвтрүүлсэн. Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтрүүлснээр аймаг, нийслэлийн мал эмнэлгүүд урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлтөө хийж, мөн халдварт, гоц халдварт, шимэгчтгэх, халдваргүй өвчний дуудлага болон өвчлөлийг бүртгэснээр Мал, амьтны гоц халдварт, халдварт, шинэ болон дахин сэргэж буй өвчний мэдээллийн сан бий болж байна.	100%
31	3.2.1.2. Мал, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн гарал, үүсэл, чанар, аюулгүй байдлыг	2019			Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, төхөөрөх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах, отор нүүдэл хийх болон бусад зорилгоор	100%

	мөшгөн тогтоох нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бий болгон ажиллуулах;				шилжилт хөдөлгөөн хийх үед мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн баталгааг сайжруулах үндэсний цогц систем буюу мал эмнэлгийн нэгдсэн систем (МЭГС)–ийг улс орон даяар нэвтрүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулан Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын даргаар батлуулж, 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн мал эмнэлгийн газар, тасаг, 332 сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт хүргүүлэв. Мөн ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, Швейцарын хөгжлийн агентлаг Ногоо алт- малын эрүүл мэнд төсөл, “Дижитал медик” ХХК-тай хамтран Мал эмнэлгийн гэрчилгээжүүлэлт, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн цахим системийг 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн мал эмнэлгийн газар, тасаг, 332 сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт мал эмнэлгийн гэрчилгээний системийг шинээр суулгах, хэрэглэгчийн нууц үгийг сэргээх, бааз дахь мэдээг ашиглах, цахим гэрчилгээ бичих, төлөвлөгөө оруулах, дуудлага үйлчилгээ хийх үзүүлэх сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, Улсын хэмжээнд мал эмнэлгийн цахим системийг нэвтрүүлж нийт 2173 малын эмчийг хамруулав.	
32	3.2.1.3. Мал, амьтны гоц халдварт, шинэ болон дахин сэргэж буй өвчнийг эрт илрүүлэх тандалтын нэгдсэн цахим бүртгэлийг сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын мал эмнэлгийн байгууллагуудад нэвтрүүлэх;	2019 - 2020			Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын Швейцарын элчин сайдын яамны хамтын ажиллагааны газартай байгуулсан гэрээ, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/167 дугаар тушаал болон малын эрүүл мэндийн нэгдсэн систем нэвтрүүлэх ажил зохион байгуулах нэгдсэн удирдамжийн дагуу 21 аймаг нийслэлийн мал эмнэлгийн газар, сумын тасгийн мэргэжилтэн, нэгжийн эмч нар, мал аж ахуй эрхлэгчид нартай хамтран 2019 оны 10 дугаар сарын 06-с 2019 оны 12 сарын 20-ны дотор сургалт зохион байгуулж нэвтрүүлсэн. Систем нэвтрүүлэлтийн ажлыг МЭЕГ, МоҮМЭХ, нийслэл, аймгуудын МЭГ, Ногоон алт малын эрүүл мэнд төсөл, Дижитал медик ХХК-ийн хамтарсан баг гүйцэтгэсэн болно. Сумын малын шилжилт хөдөлгөөнийг хянах, эргэн мөшгөх тогтолцоог бий болгох, мал амьтны өвчнийг тандах, эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг төлөвлөхөд хэрэглэгдэх, Мал, амьтны гоц халдварт, халдварт, шинэ болон дахин сэргэж буй өвчнийг эрт илрүүлэх тандалтын нэгдсэн цахим бүртгэлийг сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын мал эмнэлгийн байгууллагуудад нэвтрүүлснээр мал эмнэлгийн нэгдсэн системд мэдээллийн санг бий болгосон. Улсын хэмжээнд мал эмнэлгийн нэгдсэн системд нийт 2173 малын эмчийг хамруулав.	100%
3.2.2. Бүсийн оношилгоо, шинжилгээний лабораторийг зүүн, хангайн, баруун бүсэд өргөтгөн байгуулж, дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх;						

33	3.2.2.1. Баруун бүсэд мал эмнэлгийн лабораторийг өргөтгөн бүсийн лаборатори байгуулах	2020 - 2021			2019 онд Архангай аймгийн Мал эмнэлгийн лабораторийн барилгын шинэчлэлийн ажил Боловсрол Соёл Шинжлэх ухаан, Спортын сайдын багцаас 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байна. Тендерт шалгарсан БЗД-ийн “ЖАМ” ХХК барилгын ажлыг эхлүүлэн 30 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	Үнэлэх боломжгүй
34	3.2.2.2. Хангайн бүсэд мал эмнэлгийн лабораторийг өргөтгөн бүсийн лаборатори байгуулах;	2020 - 2021			Сэлэнгэ, Дорноговь аймагт Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын арга хэрэгслийг сайжруулах” МОН-3313 төслийн үйл ажиллагааны хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот, Дорноговь аймгийн Сайншанд хотуудын Мал эмнэлгийн лабораториудад хөрөнгө оруулалт хийгдэж дуусаад байна	Үнэлэх боломжгүй
35	3.2.2.3. Зүүн бүсэд мал эмнэлгийн лабораторийг өргөтгөн бүсийн лаборатори байгуулах;	2020 - 2021			Үе шаттайгаар хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж байна	Үнэлэх боломжгүй
3.2.3. Төв, орон нутгийн мал эмнэлэг, ариун цэвэр, оношилгооны лабораторийн барилга, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх, лабораториудад шаардлагатай эм, урвалж, оношлуур, тоног төхөөрөмжийн нөхөн хангалт хийх, зохих нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах;						
36	3.2.3.1. Мал эмнэлгийн лабораторийн барилгыг шинээр болон шинэчлэн барих, тоног төхөөрөмжөөр хангах, засвар үйлчилгээг хийх арга хэмжээг зохион байгуулах;	2019 - 2021			Өмнөговь аймгийн Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн барилгыг ашиглалтад оруулсан. Архангай аймгийн мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн барилгын ажлыг орон нутгийн санхүүжилтээр эхлүүлээд байна. Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ, Дорноговь аймгийн мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн барилгын ажлыг гүйцэтгэчийг шалгаруулах ажил хийгдэж байна. Өмнөговь аймгийн Ханбогд суманд төслийн санхүүжилтээр мал эмнэлгийн цогцолбор барьсан. ШХА-ийн Ногоон алт-малын эрүүл мэнд төслийн Архангай аймгийн Өндөр-Улаан сум, Завхан аймгийн Сантмаргац сум, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумдын Мал эмнэлгийн тасаг, МЭҮН-ийн цогцолбор барилга, байгууламжийн өргөтгөл, засвар, шинэчлэл хийх дэмжлэг үзүүлэх шалгаруулалт хийж хөрөнгө оруулалтыг хийж эхлээд байна.	70%
37	3.2.3.2. Мал эмнэлгийн лабораториудад шаардлагатай эм, урвалж, оношлуурын хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах;	2019 - 2021			2019 онд лабораториудад шаардлагатай эм, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж худалдан авах МЭТШ/2019/5 тендерт хил залгаа ОХУ, БНХАУ-д гараад байгаа гахайн африкийн мялзан, үхрийн арьсны товруут үрэвсэл зэрэг шинэ болон дахин сэргэж болзошгүй өвчний оношлуурыг тендерээр худалдан авч лабораторийн оношилгооны бэлэн байдлыг хангаад байна. НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр төв болон баруун бүсийн аймгуудын шүлхий өвчний оношилгооны чадавхыг сайжруулах зорилгоор оношлуур, хэрэглэгдэхүүн нийлүүлсэн.	70%
38	3.2.3.3. Гоц халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнийг оношлох	2019 - 2021			Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2019 онд Гоц халдварт шүлхий өвчний оношлуур, урвалж худалдан авах МЭТШ/2019/02, Мал амьтны халдварт, гоц халдварт өвчний оношлуур, эм урвалж, шил сав худалдан	100%

	оношлуурын нөөцийг орон нутгийн түвшинд бүрдүүлж, ашиглалтыг сайжруулах;				авах МЭТШ/2019/05-1, МЭТШ/2019/05-2, МЭТШ/2019/05-3, Гоц халдварт бог малын мялзан өвчний оношлуур, хэрэглэгдэхүүн худалдан авах МЭТШ/2019/04 Г-2019/04, Бруцеллэз өвчнийг эрүүлжүүлэх шинжилгээнд шаардагдах хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл худалдан авах МЭТШ/2019/03 дугаартай тендер тус тус зарласан. Бараа, материалыг тендерийн бичиг баримт, техникийн тодорхойлолт, гэрээнд заасан нөхцөлүүдийн дагуу шалган хүлээн авч УМЭАЦТЛ, МЭХ, Аймаг нийслэлийн мал эмнэлгийн лабораториудад хуваарийн дагуу хүргүүлсэн.	
3.2.4. Шинжлэх ухааны тооцоо, судалгаанд тулгуурласан тандалт судалгааг хийх загварыг сум, аймаг, бүсийн түвшинд боловсруулж, хэрэгжүүлэх, үр дүнг нэгтгэх, тандалт, шинжилгээний ажлын эдийн засгийн үр ашгийг тооцох;						
39	3.2.4.1. Тархвар зүйн судалгааны хуудасны загвар, судалгаа хийх төлөвлөгөөг боловсруулан батлуулах;	2019 - 2020			Тархварзүйн судалгаа хийх төлөвлөгөө, судалгааны загвар хуудсыг МЭЕГ-ын даргын 2019 оны А/187 дугаар тушаалаар батлуулсан.	100%
40	3.2.4.2. Баруун бүсийн 2 аймагт гоц халдварт, өвчний тандалтын загварыг боловсруулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцох;	2019 - 2020			НҮБ-ын ХХААБ болон МЭЕГ хоорондын “Монгол улсын төвийн болон баруун бүсэд бог малын мялзан өвчний тандалт судалгааг хэрэгжүүлэх” ажлын гэрээг 2019 оны 12 сарын 18-ны өдөр баталж тандалтын ажлыг 2020 оны 2 дугаар сараас эхлүүлээд байна. 2019 онд улсын хэмжээнд шүлхий өвчний тандалт шинжилгээг 21 аймаг, нийслэлийн 75 сум, дүүргийн 154 багийн 1125 өрхөөс нийт 16,875 ийлдсийн дээж цуглуулж, дээж цуглуулах ажлыг хэрэгжүүлсэн. Тандалтын ажлыг 2019 оны 5 дугаар сараас 10 дугаар сарын 07-18-ны өдөр хүртэл Баруун бүсийн 7 аймагт хийсэн шүлхийн өргөн хүрээтэй тандалт шинжилгээнд хамруулж, нийт 4725 дээж шинжилснээс 4719 дээжинд 99.87%-д шүлхийн вирусын ББУ-ийн эсрэгбием (байгалийн халдвар) илрээгүй шүлхийн халдваргүйн нотлогдлоо. Баруун бүсийн 5 аймгийн 15 сумын 30 багийн 150 өрхийн нийт 1500 малын ийлдсийн дээж шинжлэхэд вакцин таригдсан болохыг шинжилгээний үр дүн харуулав. Харин Завхан аймгийн Тэлмэн, Яруу сумдын Ямаа 100/0, Хонь 100/0, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Ямаа 50/0 Хонь 50/0 эсрэгбием илрээгүй нь тухайн сумдад БММ өвчний халдваргүй болохыг нотлов. Говь-Алтай аймгийн Ямаа 150/46(31%), Хонь 150/9(6%) 2016 онд масс вакцинжуулалт хийсэн хэдий ч 2017 онд бүх төл малыг вакцинжуулалтад хамруулж, 2018 онд вакциндаагүй байна.	100%
41	3.2.4.3. Хангайн бүсийн 2 аймагт гоц халдварт, өвчний тандалтын загварыг боловсруулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцох;	2019 - 2020			НҮБ-ийн ХХААБ-ын зөвлөх үйлчилгээний хүрээнд 2019 оны 3 улиралд хамтран загварыг боловсруулж, 9-р сард тандалтыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. НҮБ-ын ХХААБ болон МЭЕГ хоорондын “Монгол улсын төвийн болон баруун бүсэд бог малын мялзан өвчний тандалт судалгааг хэрэгжүүлэх” ажлын гэрээг 2019 оны 12 сарын 18-ны өдөр баталж, тандалтын ажлыг 2020 оны 2 дугаар сараас эхлүүлээд байна. Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн мал сүргийг "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз,	100%

					<p>аддууны ям өвчингүй, тайван байдал"-ыг тогтоохдоо ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/40 дугаар тушаалаар баталсан "Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам"-ын дагуу МЭЕГ-ын даргын 2019 оны А/76, А/155 дугаар тушаалаар шинжээчийн баг томилон эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн үнэлгээний тайланг МЭЕГ-ын дэргэдэх Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, МЭЕГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/256 дугаар тушаалаар Сэлэнгэ аймгийн үхэр сүргийг "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз өвчингүй, тайван бүс", Дархан-Уул аймгийн үхэр сүргийг "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз өвчингүй, тайван бүс"-ээр тус тус тогтоон зарласан. Улаанбаатар хотын 3,0 мянган үхэрт сүрьеэ өвчний тандалтыг хийж, үр дүнг нэгтгээд байна. 2020 онд Монгол улсын хэмжээнд үхрийн сүрьеэ, лейкоз өвчнийг тандах ажлыг хийж, цаашид бүсчилсэн байдлаар эрүүлийг баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.</p>	
42	3.2.4.4. Зүүн бүсийн 2 аймагт гоц халдварт, халдварт өвчний тандалтын загварыг боловсруулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцох;	2019 - 2020			<p>АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Энэтхэг, Номхон далайн цэргийн командалтай хамтран Онцгой Байдлын Ерөнхий газраас "Товийн чоно-2019" гамшгийн хор уршгийг арилгах олон улсын сургалт, дадлага сургуулийг 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 09 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл Дорноговь аймагт зохион байгуулсан. Тус дадлага сургуулийн хүрээнд хэрийн мал эмнэлэг дэлгэх сургуулийг зохион байгуулахтай холбогдуулан "Мал эмнэлгийн оролцоо" сэдэвт малын эмч нарын сургалтыг АНУ-ын Армийн мал эмнэлгийн корпусын малын эмч нар удирдан явуулж, Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын малын эмч нар, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Сүхбаатар аймгуудын Мал эмнэлгийн газрын удирдлагууд оролцож харилцан туршлага солилцон ажиллалаа. Дадлага сургуулийн явцыг сургалтад оролцогчдод болон олон нийтэд таниулахаар 200 ширхэг гарын авлагыг Англи хэлээр бэлтгэж, хамгаалалтын бүсийн сургалтын танхимд байршуулж гадна дотны сонирхогч, оролцогч нарт тараасан нь зохион байгуулж буй ажлаа сурталчлах боломж бүрдсэн юм.</p>	70%
3.2.5. Сум, аймаг, бүсийн түвшинд олон улсын худалдаанд саад тогтор учруулдаг, хүнсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа зарим өвчин (бруцеллез, сүрьеэ, шүлхий, бог малын мялзан)-өөс эрүүлжсэн болох талаар олон улсын жишигт нийцүүлэн баталгаажуулан мэдээлэх;						
43	3.2.5.1. Шүлхий өвчийг эрт илрүүлэх тандалт шинжилгээ, вакцинжуулалтын дараахь мониторингийг төвийн бүсийн 7000, баруун бүсийн 7000 малыг жил бүр шинжлэх	2018 - 2021			<p>Шүлхийн халдварын хүрээг тогтоох, эрүүлийг баталгаажуулах тандалт, шинжилгээнд шаардлагатай хэрэглэгдэхүүнийг хугацаанд нь нийлүүлж, улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлийн 75 сум, дүүргийн 154 багийн 1,125 өрхөөс нийт 16,875 ийлдэсний дээжид 2019 оны 5 дугаар сараас 10 дугаар сарын 18-ны өдөр хүртэл хугацаанд тандалтыг гүйцэтгэсэн. Үүнд: Баруун бүсийн 7 аймагт хийсэн шүлхийн халдвар</p>	100%



	арга хэмжээг зохион байгуулах;				илрүүлэх тандалт шинжилгээний дүнгээр 4,725 дээжийн 4,719 дээжид 99.87%-д шүлхийн вирусын бүтцийн бус уургийн эсрэгбиом (байгалийн халдвар) илрээгүй, 6 дээж эерэг буюу 0.12%-д нь шүлхийн вирусийн ББУ-ийн эсрэгбиом илрэв. Төвийн бүсийн 10 аймагт хийсэн шүлхий өвчний тандалт шинжилгээний үр дүнгээр 8,100 дээжийн 8,077 дээжид буюу 99.71%-д шүлхийн вирусийн ББУ-ийн эсрэгбиом (байгалийн халдвар) илрээгүй, 23 дээж эерэг буюу 0.28%-д нь шүлхийн вирусийн ББУ-ийн эсрэгбиом илрэв. Зүүн бүсийн нийт 5 аймаг, 18 сумын 270 өрхийн малчин өрхийн 4,050 малын ийлдэсний дээжээс 251 дээж эерэг буюу 6,19%-д нь шүлхийн вирусийн ББУ-ийн эсрэгбиом илрэв. Тандалтын үр дүнгээс харахад баруун болон төвийн бүсэд оношлуурын өвөрмөц, мэдрэг чанартай холбоотойгоор ББУ илэрсэн байж болох талтай бөгөөд зүүн бүсэд 6,1 хувьд эсрэгбиом илэрсэн нь урьдчилан сэргийлэх, үзлэг ажиглалтын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлага байгааг харуулж байна. Шүлхий өвчний ОХУ-д үйлдвэрлэсэн О, А хэвшлийн вакцин таригдсан 9 аймаг, нийслэлийн мал сүрэгт вакцин таригдсаны дараах дархлаажилтын байдлыг хянах, нийт сүргээс төлөөлөл болгон 4950 ийлдэсний дээж авч вакцинд хамрагдалтын хувийг тогтооход 21 дэх хоногт тогтсон дархлааг шалгахад О хэвшилд 84,8, А хэвшилд 4,242 дээжинд буюу 85,7 хувийн дархлаа тогтсон үр дүнтэй байна	
44	3.2.5.2. Бог малын мялзан өвчнийг эрт илрүүлэх шинжилгээ, вакцинжуулалтын дараахь мониторингийг баруун болон зүүн бүсийн 5 аймгийн 10000 мянан малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах	2018 - 2021			Вакцины дархлаа шалгах тандалтын дээжийг баруун бүсийн 5 аймаг, төвийн бүсийн 12, зүүн бүсийн 5 аймгаас нийт 7,500 дээж цуглуулах ажлыг 2019 оны 5-р сарын 30-ны, шинжилгээний ажлыг 2019 оны 9-р сарын 30-ны дотор хийж гүйцэтгэсэн. БММ өвчний халдвар тогтоох, тандалт шинжилгээний үр дүнгээр Монгол орны хэмжээнд 769 дээжид буюу 10%-д нь эсрэгбиом илрэв. Баруун бүсийн: 5 аймгийн 15 сумын 30 багийн 150 өрхийн нийт 1,500 малын ийлдэсний дээжид, үүнээс: 2018 оны 9-10 сард БММӨ-ний вакцинд хамрагдсан Баян-Өлгий аймгийн (Буянт, Дэлүүн) сумдын Ямаа 100/26 (26%), Хонь 100/34 (34%) Нийт 200/60-30%-д, Увс аймгийн Ямаа 150/20 (14%), Хонь 150/36 (24%), Нийт 300/56- 19%-д, Завхан аймгийн (Цагаанхайрхан) сумын Ямаа 50/37 (74%), Хонь 50/41 (82%), нийт 100/78-78%-д, Ховд аймгийн Ямаа 150/72 (48%), Хонь 150/69 (46%), Нийт 300/141-47%-д тус бүр вирусийн эсрэгбиом илэрсэн буюу вакцин таригдсан болохыг шинжилгээний үр дүн харуулав. Харин Завхан аймгийн Тэлмэн, Яруу сумдын Ямаа 100/0, Хонь 100/0, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Ямаа 50/0, Хонь 50/0 эсрэгбиом илрээгүй нь тухайн сумдад БММ өвчний халдваргүй болохыг нотлов. Гэтэл Говь-Алтай аймгийн Ямаа 150/46(31%), Хонь 150/9(6%) 2016 онд масс вакцинжуулалт хийсэн хэдий ч 2017 онд бүх төл малыг вакцинжуулалтад хамруулж, 2018 онд вакциндаагүй байна.	100%

					Төвийн бүс: БММ-ийн тохиолдол бүртгэгдээгүй, вакцин таригдаагүй аймаг, сум, баг, дээжийг санамсаргүй аргаар сонгов. Нийслэл, 11 аймгийн 42 сумын 88 багийн 420 өрхийн нийт 4200 малын ийлдэсний дээжид БММ өвчний эсрэгбием илрүүлэх шинжилгээгээр Хөвсгөл, Архангай, Сэлэнгэ, Дундговь, Өмнөговь, Төв, Баянхонгор, Өвөрхангай, Дархан, Орхон, Булган аймгийн Ямаа 1900/0 (0.0%), Хонь 1900/0 (0.0%) тус бүр вирусийн эсрэг бием илрээгүй нь тухайн сонгогдсон бүс нутагт БММӨ-ний халдвар байхгүйг нотлов. Улаанбаатар хотын дүүргүүдэд хонь 200/4 (2%), ямаа 200/1(0.5%)-нд эсрэг бием илэрсэн нь ЕЛИЗА оношлуурт байдаг өвөрмөц чанартай холбоотой байх талтай.	
45	3.2.5.3. Үхрийн сүрьеэ өвчнийг тандах шинжилгээг баруун бүсийн 5 аймгийн 10000 мянган малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;	2018 - 2021			Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн мал сүргийг "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз, адууны ям өвчингүй, тайван байдал"-ыг тогтоохдоо ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/40 дугаар тушаалаар баталсан "Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам"-ын дагуу МЭЕГ-ын даргын 2019 оны А/76, А/155 дугаар тушаалаар шинжээчийн баг томилон эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн үнэлгээний тайланг МЭЕГ-ын дэргэдэх Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, МЭЕГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/256 дугаар тушаалаар Сэлэнгэ аймгийн үхэр сүргийг "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз өвчингүй, тайван бүс", Дархан-Уул аймгийн үхэр сүргийг "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз өвчингүй, тайван бүс"-ээр тус тус тогтоон зарласан. Улаанбаатар хотын 3,0 мянган үхэрт сүрьеэ өвчний тандалтыг хийж, үр дүнг нэгтгээд байна. 2020 онд Монгол улсын хэмжээнд үхрийн сүрьеэ, лейкоз өвчнийг тандах ажлыг хийж, цаашид бүсчилсэн байдлаар эрүүлийг баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.	40%
46	3.2.5.4. Бруцеллэз өвчнийг тандах шинжилгээг баруун бүсийн 5 аймгийн 10000 мянган малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;	2018 - 2021			2018 онд хээлтүүлэгч малын 17 аймаг, нийслэлийн малд хийсэн бруцеллэзын ийлдэс судлалын шинжилгээнд нийт 242350 дээж шинжлэгдсэнээс илрүүлэх РБУ-аар 0.35% буюу 856 нь эерэг гарч эсрэг бием илэрсэн. Нэгээс бусад аймаг, нийслэлд халдвар илэрч сумын 46.5% (127/273), багийн 23.2% (249/1072), өрхийн 1.2% (679/54590)-д нь тархалттай байна. Малын төрлөөр авч үзвэл шинжлэгдсэн нийт буурны 0.53% (11/279), бухын 0.55% (141/25453), хуцын 0.34% (396/117816), ухнын 0.31% (304/97030) -д нь тус тус эсрэг бием илэрсэн байна. Аймгуудын дунджаар 0.02-1.7% халдварлалттай, Булган, Дархан-Уул, Өвөрхангай, УБ зэрэгт бусад аймгаас өндөр хувьтай байна. Өмнөговь аймагт эерэг дээж илрээгүй болно. 2019 онд хээлтүүлэгч малын бруцеллэзын шинжилгээнд 321 сум дүүргийн 1236 багийн 50596 өрх айлаас 294,1 мянган дээж авч, төлөвлөгөөг 79.3% дүнтэй буюу өрхийн тоо олон хамрагдсан дүнтэй гарсан. Нийт гүйцэтгэлийн байдлыг аймгуудаар	100%

					авч үзвэл 51.3%-103.8% бөгөөд малын төрлийн хувьд ойролцоогоор буур-40.3%, бух-52.4%, хуц-86.1%, ухна-82.7% хамруулсан дүнтэй гарсан байна. Бруцеллэзыг илрүүлэх РБУ-ын шинжилгээгээр эерэг гарсан дүнг ХХУ-аар баталгаажуулсан үр дүнгээс үзэхэд РБУ-аар нийт шинжилсэн дээжийн 0.26% (758/294140) нь эерэг гарсан бол баталгаажуулах ХХУ-ын шинжилгээгээр 0.2% (593/294140) нь эерэг дүн үзүүлж, баталгаажилт 78.2% -тай гарсан байна.	
47	3.2.5.5. Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлийг баталгаажуулах арга хэмжээг зохион байгуулах	2018 - 2021			Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүл болохыг баталгаажуулах ажлыг 2018 онд эхлүүлж, 2021 онд дуусгахаар төлөвлөн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/61 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. 2018 онд Увс, Завхан, Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар аймгуудаас 580 үхрийн, 887 ямааны цусны ийлдэсний сорьц, уушгины үрэвслийн шинж тэмдэгтэй үхрийн 2 сорьцыг нян судлалын шинжилгээнд тус тус цуглуулж, тандалтыг хийсэн. 2019 онд МЭХ-тэй гэрээ байгуулан санхүүжүүлж, 3000-аас дээш үхэрт түүвэр байдлаар тандалт хийх ажлыг хэрэгжүүлж байна. Нян судлал, молекул биологийн шинжилгээнд зориулж нийт 9 аймгийн Мал эмнэлгийн газраас үхрийн уушгины эмгэг өөрчлөлттэй сорьц 160, ямааны уушгины сорьц 230 сорьцыг илгээсэн байна. Судалгааны багийн гишүүд 2019 онд үхрийн 100, ямааны 188 эмгэгт сорьц цуглуулав. Тандалт судалгааны ажилд үхрээс цуглуулсан 267, ямаанаас цуглуулсан 450 сорьцыг нян судлал болон молекул биологийн судалгаанд ашиглаж байна. Үр дүнг мэргэжлийн зөвлөлийн хурлаар тус тандалтын үр дүнг хэлэлцсэн. Тухайн тандалт шинжилгээний үр дүнгээр үхрийн цээж болон ямааны годрон өвчнөөр тайван байна. 2020 онд улсын хэмжээнд тандалтыг хийж, ДМАЭМБ-ын эксперт урьж, урьдчилсан тайланг хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	100%
48	3.2.5.6. Зарим гоц болон архаг халдварт өвчнийг сум, аймгийн түвшинд баталгаажуулан мэдээллэх;	2018 - 2021			“Малын бруцеллэстэй тэмцэх стратеги, төлөвлөгөө”, МЭЭГ-ын даргын тушаалаар “Нийслэлийн үхрийн аж ахуйг бруцеллэз өвчнөөр тайван нэгж/суурийг тодорхойлж, баталгаажуулах, сүрьеэ өвчнийг тандах” ажлын хүрээнд нийслэл орчмын аж ахуйн нэгж, малчин өрхийн үхэр сүрэгт бруцеллэз, сүрьеэ өвчний тандалт шинжилгээг хийж дээрх өвчнөөс эрүүл аж ахуйн нэгж, малчин өрхийг тодорхойлж сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих замаар нийслэлийн хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангах зорилтыг тавьж, Хан- Уул дүүргийн 390 өрхийн 4113 үнээ, Сонгино хайрхан дүүргийн 706 өрхийн 8146 үнээ, Баянзүрх дүүргийн 615 өрхийн 4924 үнээ, Налайх дүүргийн 429 өрхийн 3447 үнээ, нийт 2140 малчин өрхийн 20630 үнээний сүүний 2140 дээж шинжилгээнд хамруулсан. Нийслэлийн хэмжээнд 34048 цусны дээжийг Роз-Бенгалын урвалаар	100%

					<p>шинжлэхэд 514 дээж эерэг, 33534 дээж сөрөг үр дүн үзүүлсэн байна. Үүнээс эерэг үр дүн үзүүлсэн 514 дээжид ID.vet FRANCE улсын бруцеллэз өвчний эсрэгбием илрүүлэх ЕЛИЗА урвалын цомгийг ашиглаж шинжилгээг хийхэд 283 дээжид бруцеллэзын эсрэг бием илэрсэн. Хавсран Холбох Урвалаар шинжилгээ хийхэд 131 өрхийн 248 дээжид бруцеллэзын эсрэгбием илэрсэн. Тус тайланг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, бруцеллэзоос эрүүл сүрэгтэн гэрчилгээг олгож байна. Өмнөговь аймгийн мал сүргийг "Малын бруцеллэз өвчингүй, тайван байдал"-ыг, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн мал сүргийг "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз, адууны ям өвчингүй, тайван байдал"-ыг тогтоолгох хүсэлтийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/40 дугаар тушаалаар батлагдсан "Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам"-ын дагуу МЭЕГ-ын даргын 2019 оны А/76, А/155 дугаар тушаалаар шинжээчийн баг томилон эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн үнэлгээний тайланг МЭЕГ-ын дэргэдэх мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталгаажуулж, Өмнөговь аймгийг Малын бруцеллэз өвчингүй, тайван болохыг, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийг Үхрийн сүрьеэ, лейкоз өвчингүй тайван болохыг тус тус баталгаажуулав</p>	
3.3.1. Бүх шатны мал эмнэлгийн байгууллагуудад вакцин, эм бэлдмэлийг хадгалах хөргүүр, хүйтэн хэлхээгээр тээвэрлэх ложистик сүлжээг байгуулах;						
49	3.3.1.1. Зүүн бүсийн мал эмнэлгийн байгууллагуудад вакцин, биобэлдмэлийг хадгалах, зөөвөрлөх чадавхийг сайжруулах;	2020 - 2021			<p>Сүхбаатар, Дорнод аймгийн мал эмнэлгийн газрын вакцин хадгалах хөргүүрийн засвар үйлчилгээг хийлгэж хэвийн ажиллагаанд оруулсан. Бүх аймгийн Мал эмнэлгийн газарт ашиглагдаж байгаа вакцин, оношлуур хадгалдаг хөргүүрийн ажиллагаа ашиглалтыг сайжруулах зорилгоор МЭЕГ-ын 2020 оны төсөвт зардлыг тусган засвар, үйлчилгээ хийхээр төлөвлөөд байна. Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн вакцин хадгалах хөргүүрийн чадавхийг сайжруулахад төсөл, хөтөлбөрөөс хөрөнгө оруулах саналыг холбогдох байгууллагуудад илгээгээд байна.</p>	Үнэлэх боломжгүй
50	3.3.1.2. Хангайн бүсийн мал эмнэлгийн байгууллагуудад эм, биобэлдмэлийг хадгалах, зөөвөрлөх чадавхийг сайжруулах;	2020 - 2021			<p>ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А-52 дугаар тушаалаар ХХААХҮ-ийн салбарт 2020 онд төвлөрсөн арга хэмжээ болон хөрөнгө оруулалт санхүүжилтээр худалдан авах бараа, ажил үйлчилгээний жагсаалтад "Орон нутагт малын вакцин тээвэрлэх автомашин" худалдан авахаар 160.0 сая төгрөгийн эх үүсвэр батлагдсан. МЭЕГ-ын даргын 2020 оны А-30 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороо байгуулан ажиллаж байна. Бүх аймгийн Мал эмнэлгийн газарт ашиглаж байгаа вакцин, оношлуур хадгалдаг хөргүүрийн ажиллагаа ашиглалтыг сайжруулах зорилгоор МЭЕГ-ын 2020 оны төсөвт зардлыг тусган засвар, үйлчилгээ хийхээр төлөвлөөд байна. Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн вакцин хадгалах хөргүүрийн чадавхийг сайжруулахад төсөл, хөтөлбөрөөс хөрөнгө оруулах саналыг холбогдох байгууллагуудад илгээгээд байна.</p>	Үнэлэх боломжгүй

51	3.3.1.3. Төвийн бүсийн мал эмнэлгийн байгууллагуудад эм, биобэлдмэлийг хадгалах, зөвөрлөх чадавхийг сайжруулах;	2020 - 2021			Бүх аймгийн Мал эмнэлгийн газарт ашиглаж байгаа вакцин, оношлуур хадгалдаг хөргүүрийн ажиллагаа ашиглалтыг сайжруулах зорилгоор МЭЕГ-ын 2020 оны төсөвт зардал тусган засвар, үйлчилгээ хийхээр төлөвлөөд байна. Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн вакцин хадгалах хөргүүрийн чадавхийг сайжруулахад төсөл, хөтөлбөрөөс хөрөнгө оруулах саналыг холбогдох байгууллагуудад илгээгээд байна.	Үнэлэх боломжгүй
52	3.3.1.4. Баруун бүсийн мал эмнэлгийн байгууллагуудад эм, биобэлдмэлийг хадгалах, зөвөрлөх чадавхийг сайжруулах.	2020 - 2021			Бүх аймгийн Мал эмнэлгийн газарт ашиглаж байгаа вакцин, оношлуур хадгалдаг хөргүүрийн ажиллагаа ашиглалтыг сайжруулах зорилгоор МЭЕГ-ын 2020 оны төсөвт зардлыг тусган засвар, үйлчилгээ хийхээр төлөвлөөд байна. Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн вакцин хадгалах хөргүүрийн чадавхийг сайжруулахад төсөл, хөтөлбөрөөс хөрөнгө оруулах саналыг холбогдох байгууллагуудад илгээгээд байна.	Үнэлэх боломжгүй
3.3.2. Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг тандан судалгааны үр дүнд үндэслэн төлөвлөж хэрэгжүүлэх;						
53	3.3.2.1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг эрсдэл бүхий бүс, аймгуудад зохион байгуулах;	2019 - 2021			Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг эрсдэл бүхий зүүн бүсийн 5 аймгийн 57 сумын нийт 5,8 сая толгой мэдрэтгий мал сүргийг хамруулж, нийт 796,5 сая төгрөгийн санхүүжилтийг тарилга гүйцэтгэсэн Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд гүйцэтгэлээр олгоод байна.	100%
54	3.3.2.2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг эрсдэл бүхий бүс, аймгуудад зохион байгуулах;	2019 - 2021			Шүлхий өвчний эрсдэлтэй хилийн боомт бүхий зүүн болон говийн бүсийн аймаг, төвийн бүсийн зарим аймаг буюу нийт 9 аймгийн 118 суманд 2 удаагийн давталтайгаар нийт 22.7 сая толгой мэдрэмгий мал сүрийг хамруулан дархлаажуулж, нийт 3.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тарилга гүйцэтгэсэн Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд гүйцэтгэлээр олгоод байна.	100%
55	3.3.2.3. Хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг эрсдэл бүхий бүс, аймгуудад зохион байгуулах;	2019 - 2021			Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зүүн бүсийн 5 аймгийн 62 сумын нийт 2,9 сая толгой хонь, хурга хамруулж, нийт 427,1 сая төгрөгийн санхүүжилтийг тарилга гүйцэтгэсэн Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд гүйцэтгэлээр олгоод байна.	100%
56	3.3.2.4. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах;	2019 - 2021			Малын бруцеллэзоос сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээнд 2018 онд Өмнөговь аймгаас бусад 21 аймаг, нийслэлийн охин тугал 689,8 мянга, хурга 7,48 сая, хурга 4,84 сая толгой, нийт 13,0 сая толгой охин төлийг хамруулж 97,0%-тай гүйцэтгэж, вакцины үйлчилгээний хөлсөнд 1,84 тэрбум төгрөгийг олгосон. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторитой “Бруцеллэзын вакцинжуулалтын дараах мониторинг хийх ажил гүйцэтгэх” МЭЕГ2018/АГ-04 дугаартай гэрээг 33,2 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр байгуулан вакцинжуулалтын чанар, үр дүнг үнэлэх ажлыг хийсэн. Тус гэрээний хүрээнд Увс, Завхан, Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ аймгийн 16	100%

					<p>сумын 960 тугал, 4160 хурга, 4160 ишиг, нийт 9228 цусны дээжид шинжилгээ хийсэн. Тус “Бруцеллёзын вакцинжуулалтын дараах мониторинг хийх ажил гүйцэтгэх” шинжилгээний дүнгээр улсын хэмжээнд вакцины дархлааны идэвх 73,4%-тай гарсан ба Завхан аймгийн Тэлмэн, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын вакцинжуулалтын дүн хангалтгүй гарсан байна. 2019 онд улсын хэмжээнд 892,3 мянган тугал вакцинжуулахаас 831,6 мянган тугал, 8,15 сая хурга вакцинжуулахаас 8,96 сая хурга, 6,82 сая ишиг вакцинжуулахаас 5,41 сая ишиг, нийт 15,86 сая толгой төл мал вакцинжуулахаас 15,21 сая толгой охин төлийг вакцинжуулж, 95,9%-тай гүйцэтгэж дууссан. УМЭАЦТЛ-той гэрээ байгуулан гүйцэтгэсэн тандалтаар нийт 8 аймгийн, 16 сумын, 315 өрх, айлаас бүгд 9088 цусны дээж үүнээс 4099 хурга, 4151 ишиг, 838 тугалын ийлдэсний дээжид шинжилгээ хийхэд 7775 дээж эерэг, 1313 дээж сөрөг гарч, сумдаар нь авч үзвэл 77-97%-ийн дархлаа тогтсон гэсэн дүн гарсан байна. Монгол орны Зүүн, баруун, төвийн бүсийн 8 аймгийн 16 сумын нийт 9088 толгой төл малд бруцеллёзын вакцинжуулалтын мониторинг хийсэн дүнгээр малын дархлааны хариу урвалын төвшин 85.5% байв.</p>	
57	3.3.2.5. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 18 нэрийн өвчний вакцинжуулалтыг голомт бүхий бүсүүдэд зохион байгуулах;	2019 - 2021			<p>2018 онд Биокомбинат ТӨААТҮГ-тай байгуулсан “Мал эмнэлгийн зориулалт бүхий биобэлдмэл 2018 онд худалдах, худалдан авах” гэрээгээр 19 нэрийн вакцин, тарилгын шингэнийг 3,278,470,891.90 төгрөг, 8 нэрийн өвчнийг илрүүлэх болон баталгаажуулах оношилгоонд шаардагдах оношлуурыг 20,642,318.00 төгрөг, бруцеллэз өвчнөөс сэргийлэх вакциныг 2,092,284,761.10 төгрөг, нийт 5,391,397,971.00 /Таван тэрбум гурван зуун ерэн нэгэн сая гурван зуун ерэн долоон мянга есөн зуун далан нэг/ төгрөгт багтаан нийлүүлэхээр гэрээ байгуулсан. Тус гэрээний дагуу 20,0 сая толгой малыг 19 нэрийн вакцинд хамруулах 119,5 тонн шингэн, 12,7 сая тун хуурай вакцин, 698,6 мянган малыг шинжлэх оношлуур, 732,1 мян.тун штамм-19 омог, 12,7 сая тун рев-1 омгийн вакциныг 22 аймгийн ХХААХҮГ-ын мал эмнэлгийн хэлтэст, нийслэлийн мал эмнэлгийн газар, УМЭАЦТЛ, Мал эмнэлгийн хүрээлэнд зориулалтын тээврийн хэрэгслээр хүргэж өгсөн байна. Мал, эмнэлгийн урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээнд 19 нэрийн вакцинжуулалтад 20,0 сая толгой мал хамруулахаас жилийн эцсийн мэдээгээр 19,14 сая толгой малыг хамруулж, 95.7%-тай биелсэн байна. Засгийн газрын 225 дугаар тогтоолын 1,2,3 дугаар хавсралтын дагуу Биокомбинат ТӨААТҮГ-аас галзуу, боом, цусан халдварт, шөвөг яр гэх мэт 19 нэрийн вакцинд 23,1 сая толгой мал, бруцеллэзоос сэргийлэх вакцин 15,8 сая толгой охин төлийг хамруулах вакцин, 7 нэрийн өвчний шинжилгээнд 604,1 мянган малыг</p>	100%

					хамруулах оношлуурыг үйлдвэрлэн орон нутагт хүргүүлсэн. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд улсын хэмжээнд 23,15 сая толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөснөөс 2019 оны жилийн эцсийн мэдээгээр 22,48 сая толгой мал, амьтан хамруулж, 98,4%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.	
3.3.3. Дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандан судалгаа, лабораторийн шинжилгээний аргаар үнэлэж хянах;						
58	3.3.3.1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар хийх;	2018 - 2021			Бог малын мялзан өвчний вакцины дархлаа шалгах тандалт шинжилгээг 2019 онд уг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин таригдсан зүүн бүсийн 5 аймгийн 34 сумын 65 багийн 355 өрхийн нийт 7,100 ийлдэсний дээж цуглуулж шинжилгээг УМЭАЦТЛ-иос аймаг бүрд нэг шинжээч тухайн аймгийн МЭЛ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэсэн нь аймгийн МЭЛ-ийн мэргэжилтнүүдийг сургах давхар зорилготой байв. Лабораторийн шинжилгээгээр Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Сүхбаатар, Дорнод аймгуудад дунджаар 66,3 хувийн дархлаа тогтсон болох нь харагдаж байна. Цаашид 2020 онд орон нутагт хийгдэж буй вакцинжуулалтын явцын болон гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах ажлыг эрчимжүүлэхээр төлөвлөд байна.	70%
59	3.3.3.2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар зохион байгуулах;	2018 - 2021			Шүлхий өвчний вакцины дархлаа шалгах тандалт шинжилгээнд ОХУ-н О, А хэвшлийн вакцин таригдсан 9 аймаг, нийслэлийн мал сүрэгт вакцин таригдсаны дараах дархлаажилтын байдлыг хянах, нийт сүргээс төлөөлөл болгон 4950 ийлдсийн дээж авч вакцинд хамрагдалтын хувийг тогтоох шинжилгээ хийсэн. Шүлхий өвчний вакцины дархлаа шалгах тандалтыг вакцин тарьснаас хойш 21 дэх хоногт тогтсон дархлааг шалгахад О хэвшилд 84,8, А хэвшилд 85,7 хувийн дархлааны түвшин тогтсон үр дүнтэй байна. Цаашид 2020 онд вакцины явцын болон гүйцэтгэлийн хяналт, тарилгын үр дүнд тавих хяналтыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхээр төлөвлөж байна.	70%
60	3.3.3.3. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар зохион байгуулах;	2018 - 2021			Малын бруцеллэзоос сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээнд 2018 онд Өмнөговь аймгаас бусад 21 аймаг, нийслэлийн охин тугал 689,8 мянга, хурга 7,48 сая, хурга 4,84 сая толгой, нийт 13,0 сая толгой охин төлийг хамруулж 97,0%-тай гүйцэтгэж, вакцины үйлчилгээний хөлсөнд 1,84 тэрбум төгрөгийг олгосон байна. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторитой “Бруцеллэзын вакцинжуулалтын дараах мониторинг хийх ажил гүйцэтгэх” МЭЕГ2018/АГ-04 дугаартай гэрээг 33,2 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан вакцинжуулалтын чанар, үр дүнг үнэлэх ажлыг хийсэн. Тус гэрээний хүрээнд Увс, Завхан, Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ аймгийн 16 сумын 960 тугал, 4160 хурга, 4160 ишиг, нийт 9228 цусны дээжид шинжилгээ хийсэн. Тус “Бруцеллэзын вакцинжуулалтын дараах мониторинг хийх ажил гүйцэтгэх” шинжилгээний дүнгээр	100%

					<p>улсын хэмжээнд вакцины дархлааны идэвх 73,4%-тай гарсан ба Завхан аймгийн Тэлмэн, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын вакцинжуулалтын дүн хангалтгүй гарсан байна. 2019 онд улсын хэмжээнд 892,3 мянган тугал вакцинжуулахаас 831,6 мянган тугал, 8,15 сая хурга вакцинжуулахаас 8,96 сая хурга, 6,82 сая ишиг вакцинжуулахаас 5,41 сая ишиг, нийт 15,86 сая толгой төл мал вакцинжуулахаас 15,21 сая толгой охин төлийг вакцинжуулж, 95,9%-тай гүйцэтгэж дууссан. УМЭАЦТЛ-той гэрээ байгуулан, удирдамж, хуваарийн дагуу аймгийн малын эмч нарын оролцоотой хамтран хийж гүйцэтгэв. Тухайн тандалтаар аймаг тус бүрийг УМЭАЦТЛ-иос эмч нар хариуцан ажиллаж, нийт 8 аймгийн, 16 сумын, 315 өрх, айлаас бүгд 9088 цусны дээж цуглуулан шинжлүүлэв. Вакцины дараах мониторингийн шинжилгээнд 4099 хурга, 4151 ишиг, 838 тугалын ийлдэсний дээжид шинжилгээ хийхэд 7775 дээж эерэг, 1313 дээж сөрөг гарч, сумдаар нь авч үзвэл 77-97%-ийн дархлаа тогтсон гэсэн дүн гарсан байна. Монгол орны Зүүн, Баруун, Төвийн бүсийн 8 аймгийн 16 сумын нийт 9088 толгой төл малд бруцеллёзын вакцинжуулалтын мониторинг хийсэн дүнгээр малын дархлааны хариу урвалын төвшин 85.5% байв.</p>	
3.3.4. Мал, амьтны гоц халдварт, зооноз, халдварт өвчний эрсдлийн дүн шинжилгээнд үндэслэн шаардлагатай вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх;						
61	3.3.4.1. Баруун бүсэд гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх;	2019 - 2021			<p>Халдваргүйтгэлийн бодисын 4 багц нээлттэй тендерийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, халдваргүйтгэлийн 3 төрлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлж халдварт, гоц халдварт өвчний гаралт, хяналтын цэгийн байршил, хилийн бүс нутгийн аймгуудын эрсдэлтэй нөхцөл байдалд тулгуурлан орон нутагт нийлүүлэх хуваарийг гаргаж, халдваргүйтгэлийн бодисыг орон нутагт хүргүүлэн ажилласан. МЭЕГ болон НҮБ-ын ХХААБ-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд баруун бүсийн 7 аймагт 5 нэрийн 108 тооны шүлхийн өвчний түргэн оношлуур, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор 2019 оны 05-р сард нийлүүлсэн. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг Биокомбинат УТҮГ-тай гэрээ байгуулан улсын төсвөөс боом, галзуу зэрэг 7 нэрийн вакцинд 1,2 сая толгой мал хамруулах вакциныг 64,9 сая төгрөгөөр нийлүүлсэн. Малыг бруцеллёзоос сэргийлэх 4,0 сая тун вакциныг 623,2 сая төгрөгөөр Биокомбинат УТҮГ-аас худалдан авч нийлүүлж, дархлаажуулалтын ажлыг 8 сард хийж дууссан. Баруун бүсийн аймгуудад НИ-СОР 1400 кг-ийг 38,769,220, Суперкилл 2000 кг-ийг 36,000,000, Хлорын шохой 5500 кг-ийг 22,000,000, Халдвар хамгааллын нэг удаагийн иж бүрдэл хувцас 1500 ширхэг 21,750,000, олон удаагийн иж бүрдэл хувцас 50ш 6,500,000, Халдваргүйтгэлийн автомас 50 ширхэг 5,000,000 нийт</p>	100%



					130,019,220 төгрөгийн бараа материал хүргүүлж нөөц бүрдүүлсэн.	
62	3.3.4.2. Хангайн бүсэд гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлэх;	2019 - 2021			Халдваргүйтгэлийн бодисын 4 багц нээлттэй тендерийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, халдваргүйтгэлийн 3 төрлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлж халдварт, гоц халдварт өвчний гаралт, хяналтын цэгийн байршил, хилийн бүс нутгийн аймгуудын эрсдэлтэй нөхцөл байдалд тулгуурлан орон нутагт нийлүүлэх хуваарийг гаргаж, халдваргүйтгэлийн бодисыг орон нутагт хүргүүлэн ажилласан. МЭЕГ болон НҮБ-ын ХХААБ-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Хангайн бүсийн 4 аймагт 10 нэрийн 200 тооны төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор 2019 оны 05-р сард нийлүүлсэн. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг Биокомбинат УТҮГ-тай гэрээ байгуулан улсын төсвөөс боом, галзуу зэрэг 7 нэрийн 4,5 мянган литр шингэн, 276,5 мянган тун хуурай вакциныг 192,9 сая төгрөгөөр нийлүүлсэн. Малын бруцеллёзоос сэргийлэх 3,9 сая тун вакциныг 756,1 сая төгрөгөөр Биокомбинат УТҮГ-аас нийлүүлж, дархлаажуулалтын ажлыг 8 сард хийж дууссан. Хангай бүсийн аймгуудад HI-COP 1980 кг-ийг 54,830,754, Суперкилл 3200 кг-ийг 57,600,000, Хлорын шохой 8000 кг-ийг 32,000,000, Халдвар хамгааллын нэг удаагийн иж бүрдэл хувцас 2400 ширхэг 34,800,000, олон удаагийн иж бүрдэл хувцас 85ш 11,050,000, Халдваргүйтгэлийн автомакс 80 ширхэг 8,000,000, нийт 140,680,754 төгрөгийн бараа материал хүргүүлж, нөөц бүрдүүлсэн.	100%
63	3.3.4.3. Төвийн бүсэд гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлэх;	2019 - 2021			Халдваргүйтгэлийн бодисын 4 багц нээлттэй тендерийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, халдваргүйтгэлийн 3 төрлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлж халдварт, гоц халдварт өвчний гаралт, хяналтын цэгийн байршил, хилийн бүс нутгийн аймгуудын эрсдэлтэй нөхцөл байдалд тулгуурлан орон нутагт нийлүүлэх хуваарийг гаргаж, халдваргүйтгэлийн бодисыг орон нутагт хүргүүлэн ажилласан. МЭЕГ болон НҮБ-ын ХХААБ-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд төвийн бүсийн 5 аймагт 10 нэрийн 404 тооны төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор 2019 оны 05-р сард нийлүүлсэн. Төвийн бүсийн 3 аймаг, нийслэлд 5,7 сая тунг шүлхийн вакциныг олгож урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг Биокомбинат УТҮГ-тай гэрээ байгуулан улсын төсвөөс боом, галзуу зэрэг 7 нэрийн 1,4 мянган литр шингэн, 610,2 мянган тун хуурай вакциныг 67,2 сая төгрөгөөр нийлүүлсэн. Малын бруцеллёзоос сэргийлэх 5,5 сая тун вакциныг 385,6 сая төгрөгөөр Биокомбинат УТҮГ-аас нийлүүлж, дархлаажуулалтын ажлыг 8 сард хийж дууссан. Төвийн бүсийн аймгуудад HI-COP 1550 кг 42,923,065,	100%

					Суперкилл 2400 кг 43,200,000, Хлорын шохой 6500 кг 26,000,000, Халдвар хамгааллын нэг удаагийн иж бүрдэл хувцас 1800 ширхэг 26,100,000, олон удаагийн иж бүрдэл хувцас 70ш 9,100,000, Халдваргүйтгэлийн автомакс 60 ширхэг 6,000,000 төгрөг, нийт 153,323,065 төгрөгийн бараа материал хүргүүлж, нөөц бүрдүүлсэн.	
64	3.3.4.4. Зүүн бүсэд гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлэх;	2019 - 2021			Халдваргүйтгэлийн бодисын 4 багц нээлттэй тендерийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, халдваргүйтгэлийн 3 төрлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлж халдварт, гоц халдварт өвчний гаралт, хяналтын цэгийн байршил, хилийн бүс нутгийн аймгуудын эрсдэлтэй нөхцөл байдалд тулгуурлан орон нутагт нийлүүлэх хуваарийг гаргаж, халдваргүйтгэлийн бодисыг орон нутагт хүргүүлэн ажилласан. МЭЕГ болон НҮБ-ын ХХААБ-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд төвийн бүсийн 5 аймагт 10 нэрийн 404 тооны төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор 2019 оны 05-р сард нийлүүлсэн. Төвийн бүсийн 3 аймаг, нийслэлд 5,7 сая тунг шүлхийн вакциныг олгож урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг Биокомбинат УТҮГ-тай гэрээ байгуулан улсын төсвөөс боом, галзуу зэрэг 7 нэрийн вакцинд 1,5 сая толгой мал хамруулах 2,0 мянган литр шингэн, 675,0 мянган тун хуурай вакциныг 78,9 сая төгрөгөөр нийлүүлсэн. Малын бруцеллёзоос сэргийлэх 2,4 сая тун вакциныг 545,5 сая төгрөгөөр Биокомбинат УТҮГ-аас нийлүүлж, дархлаажуулалтын ажлыг 8 сард хийж дууссан. Зүүн бүсийн аймгуудад НИ-СОР 840 кг 23,261,532, Суперкилл 1200 кг 21,600,000, Хлорын шохой 4000 кг 16,000,000, Халдвар хамгааллын нэг удаагийн иж бүрдэл хувцас 900 ширхэг 13,050,000, олон удаагийн иж бүрдэл хувцас 30ш 3,900,000, Халдваргүйтгэлийн автомакс 30 ширхэг 3,000,000 төгрөг, нийт 80,811,532 төгрөгийн бараа материал хүргүүлж, нөөц бүрдүүлсэн.	100%
3.3.5. Гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины дотоодын үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлийг шат дараатай хэрэгжүүлж, вакцины хэрэгцээг дотоодоос бүрэн хангах.						
65	3.3.5.1. Вирусын гаралтай вакцины үйлдвэр байгуулах, үйлдвэрлэлийн технологийг шинэчлэх;	2019 - 2021			Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн Төрийн өмчийн үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай 186 дугаар тогтоолоор Биокомбинат УТҮГ-ыг Биокомбинат ТӨААТҮГ болгон өөрчилсөн. Тус тогтоолоор төрийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулсантай холбогдуулан Биокомбинат ТӨААТҮГ-ын удирдлагыг мэргэжлийн багаар гүйцэтгүүлэн ажиллахыг ХХААХҮ-ий сайд, ТӨБЗГ-т тус тус даалгасан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн А-294 дүгээр тушаалаар “Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг батлуулан ажиллаж, мал эмнэлгийн салбарын болон	40%

				байгууллагуудад тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж байна. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газар хооронд байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн хэлэлцээрийн хугацаа дууссан тул 2017 онд уг зээлийн гэрээний хугацааг 2019 оны 05 дугаар сарын 11-ийг хүртэл дахин 2 жилээр сунгасан юм. Энэ хугацаанд “Сонгино дахь Биокомбинат ТӨҮГ-ын тоног төхөөрөмжийг шинэчлэх” тендерийг Монголын тал Унгарын холбогдох аж ахуйн нэгжүүдийн дунд нээлттэй хэлбэрээр 2 дахь удаагаа зарлан 2018 оны 10 дугаар сард тендер хүлээн авахад оролцогч Унгарын аж ахуйн нэгж нь нийт 57.5 сая ам.доллараар гүйцэтгэх үнийн санал ирүүлсэн. Энэ тендер Унгар улсад зарлагдаж, хэрэгжих боломж бүрдээд байна. Үйлдвэрлэлийн жилд мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэхэд шаардлагатай нэн яаралтай үеийн зарим вакциныг шинээр үйлдвэрлэхээр төлөвлөж, ОХУ-ын Бүх холбоотын малын эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран өтгөрүүлэг савлах цехийг нээж, 2-3,0 сая тун шүлхийн вакциныг дотооддоо үйлдвэрлэхээр төлөвлөж байгаа бөгөөд Цөмийн энергийн агентлагийн төслийн хүрээнд Мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран ажиллана. 2020 онд шаардагдах вакцины үйлдвэрлэлийг 2019 оны 9 дүгээр сарын 15-наас эхлэн ажиллаж цаашид вакциныг технологийн хугацаанд нийлүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.	
66	3.3.5.2. Биобэлдмэлийг орон нутагт хүргэх хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийг сайжруулах;	2019 - 2021		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А-52 дугаар тушаалаар орон нутагт вакцин тээвэрлэн хүргэхэд хэрэглэх хөргүүртэй машиныг худалдан авч Биокомбинат УТҮГ-т нийлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Тус бүтээгдэхүүн нийлүүлэх тендерийн үнэлгээний хороог байгуулан ажлыг эхлүүлээд байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А-52 дугаар тушаалаар орон нутагт вакцин тээвэрлэн хүргэхэд хэрэглэх хөргүүртэй машиныг худалдан авч Биокомбинат УТҮГ-т нийлүүлэхээр төлөвлөн, бүтээгдэхүүн нийлүүлэх тендерийн үнэлгээний хороог байгуулан ажлыг эхлүүлээд байна. 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Малын эмч нарын анхдугаар хурлаар зөврийн хүргүүрийг 330 сумдад тус тус олгон ажиллав.	40%
67	3.3.5.3. Хэрэглээнд тулгуурлан вакцины сав, баглаа боодлыг шинэчлэн сайжруулах;	2019 - 2021		Шингэн вакцины /жилд дунджаар 120000-135000/ литр үйлдвэрлэдэг/ резинэн бөглөө, хөнгөн цагаан малгайвчийг өөрчилж олон улсын эм үйлдвэрлэлийн стандартад нийцсэн хэрэглэхэд хялбар, антисептик, асептикийг шаардлагыг хангасан бөглөө /Buthyl rubber/-тэй лонхонд савладаг технологид шилжүүллээ. Мөн шингэн вакцины лонхны шилний найрлагын үзүүлэлтүүд, устөрөгчийн ионы төвшрүүлэг /ph/-ийн хэмжээг олон улсын	100%

					хүн болон малын эмийн үйлдвэрлэлд тавигддаг шаардлагад нийцсэн шилэн лонхонд савлаж хэрэглээнд гаргаж байна. Үүний үр дүнд вакцины чанар нь үйлдвэрлэгчээс хэрэглэгчдэд хүрэх хүртлээ бүрэн хадгалагдах боломжтой боллоо. Монгол орны бэлчээрийн мал аж ахуйн бэлчээрийн онцлог болон хэрэглэгчдийн санал хүсэлтийг үндэслэн зарим нэр төрлийн хуурайшуулсан биобэлдмэл /вакцин, оношлуур/-ийн нэг цодонд агуулагдах тун, хэмжээг багасган савлаж байна.	
68	3.3.5.4. Шинээр зохион бүтээгдсэн вакцин, оношлуурыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	2019 - 2021			Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газар хооронд байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн хэлэлцээрийг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр УИХ-аар хэлэлцэн баталж уг зээлийн гэрээний 2 жилээр сунгасан юм. Энэ хугацаанд “Сонгино дахь Биокомбинат УТҮГ-ын барилга, тоног төхөөрөмжийг шинэчлэх” тендерийг Монголын тал Унгарын холбогдох аж ахуйн нэгжүүдийн дунд нээлтэй хэлбэрээр зарлан гүйцэтгүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх вакциныг дотооддоо үйлдвэрлэх зорилгоор Цөмийн энергийн агентлагийн санхүүжилттэй вирусны вакцины үйлдвэрлэлийн цехийг 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдөр ашиглалтад оруулаад байна. Энэхүү вирусны вакцин үйлдвэрлэлийн цех ашиглалтанд орсноор шүлхийн вакцины өтгөрүүлгийг дотооддоо шингэлэн савлаж, гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх болон нэн яаралтай нөхцөлд богино хугацаанд шуурхай арга хэмжээ авах боломж бүрдэж байгаа юм. Мал эмнэлгийн хүрээлд үйлдвэрлэсэн нийт 21 нэр төрлийн 65.0 сая төгрөгийн оношлуурыг орон нутагт нийлүүлж, оношилгоо шинжилгээнд ашиглаж байна.	100%
3.4.2. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлохтой холбогдсон чанар, эрүүл ахуй, хорио цээрийн гэрээ, хэлцэлийг гадаад улстай шинэчлэн байгуулах, өргөжүүлэх;						
69	3.4.2.1. Экспортын эрх авсан мал төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийн байгууламж, технологийн үйл ажиллагааны горимыг импортлогч орон болон Евразийн эдийн засгийн гишүүн орнуудын мал эмнэлгийн дүрэм, журам, норм, норматив, шаардлагад нийцүүлэн баталгаажуулах;	2019 - 2021			Экспортын эрх авсан мал төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийн байгууламж, технологийн үйл ажиллагааны горимыг импортлогч орон болон Евразийн эдийн засгийн гишүүн орнуудын мал эмнэлгийн дүрэм, журам, норм, норматив, шаардлагад нийцүүлэн баталгаажуулах ажлын хүрээнд БНХАУ-аас ирүүлсэн саналын дагуу мах, махан бүтээгдэхүүн боловсруулах аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хянан магадалгааг улсын хэмжээнд ХХААХҮЯ, МЭЕГ, МХЕГ-ын хамтарсан ажлын хэсэг 69 мах төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрт хийсэн. Хянан магадалгаагаар сайн дүгнэгдсэн 25 үйлдвэрийн нэрсийг БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн ба тус газраас 2019 оны 12 дугаарын 10-нд 4 хүний бүрэлдэхүүнтэй эрсдэлийн үнэлгээний баг ХХААХҮЯ, МЭЕГ, МХЕГ-тай хамтран нэр бүхий үйлдвэрүүдэд хянан магадалгааг хийсэн.	100%
70	3.4.2.2. Махны үйлдвэрүүдэд мөрдөх мал эмнэлэг, эрүүл ахуйн шаардлага, мах, махан бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдлыг	2019 - 2021			Махны үйлдвэрүүдэд мөрдөх мал эмнэлэг, эрүүл ахуйн шаардлага, мах, махан бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдлыг хянан баталгаажуулах зохистой дадлыг нэвтрүүлэх ажлын хүрээнд хүнсний мал бэлтгэх, тээвэрлэх, тууварлах, үйлдвэрт хүлээн авах, төхөөрөх үед мал эмнэлэг-арин цэврийн үзлэг, шинжилгээ хийх, үнэлэх стандарт ажиллагааны түр	100%

	хянан баталгаажуулах зохистой дадлыг нэвтрүүлэх;				заавар-ыг боловсруулан МЭЕГ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар батлуулан аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газарт хүргүүлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна. ХХААХҮЯ-ны дэргэд хэрэгжиж байгаа олон улсын хөдөлмөрийн байгууллагын санхүүжилттэй UNIDO төслийн дэмжлэгтэй Ховд, Баян-Өлгий аймаг, Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа мал төхөөрөх үйлдвэрүүдэд ISO22000, HACCP, HALAL стандартыг нэвтрүүлэх урьдчилсан үнэлгээ хийлгэх зорилгоор олон улсын эксперт урьж ажиллуулж, 40 мал нядлах, төхөөрөх үйлдвэрийн малын эмч, технологич нарт дадлага олгох 5 хоногийн сургалт зохион байгуулсан. Уг төсөлтэй хамтран нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа Цалуут импекс, Meat фүүдс компаний махын үйлдвэрт HACCP, HALAL стандарт нэвтрүүлэх олон улсын аудитыг 2020 онд хийлгэхээр төлөвлөөд байна.	
71	3.4.2.3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн гарал, үүсэл, чанар, аюулгүй байдлыг мөшгөн тогтоох нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бий болгон ажиллуулах;	2019 - 2021			Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, төхөөрөх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах, отор нүүдэл хийх болон бусад зорилгоор шилжилт хөдөлгөөн хийх үед мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн баталгааг сайжруулах үндэсний цогц систем буюу мал эмнэлгийн нэгдсэн систем (МЭНС)-ийг улс орон даяар нэвтрүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулан Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын даргаар батлуулж, 22 аймаг, нийслэлийн 6 дүүргийн мал эмнэлгийн газар, тасаг, 332 сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт хүргүүлэв. Манай байгууллага ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, Швейцарын хөгжлийн агентлаг Ногоо алт-малын эрүүл мэнд төсөл, “Дижитал медик” ХХК-тай хамтран Мал эмнэлгийн гэрчилгээжүүлэлт, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн цахим системийг 22 аймаг, нийслэлийн 6 дүүргийн мал эмнэлгийн газар, тасаг, 332 сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт мал эмнэлгийн гэрчилгээний системийг шинээр суулгах, хэрэглэгчийн нууц үгийг сэргээх, бааз дахь мэдээг ашиглах, цахим гэрчилгээ бичих, мал эмнэлгийн арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл оруулах, дуудлага үйлчилгээ хийх үзүүлэх сургалтад Улсын хэмжээнд мал эмнэлгийн цахим системийг нэвтрүүлж нийт 2173 малын эмчийг хамруулав. Мал эмнэлгийн нэгдсэн системийн хүрээнд нийт 64571 ширхэг мал эмнэлгийн цахим гэрчилгээ иргэн, аж ахуй нэгжид олгоод байна. МЭГ-ний систем болон лабораторийн мэдээлэл агуулсан серверийг Үндэсний дата төв байршуулан мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хөдөө орон нутгаас бэлтгэн нийлүүлж байгаа амьд мал, амьтны	100%

					гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, тээвэрлэх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах үед цагдаагийн 44 пост, мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын 10 цэгээр дамжуулан хөдөлгөөнийг хяналт тавьж ажиллаж байна.	
3.4.3.а. Экспортын зориулалттай махны үйлдвэрийг түшиглэн худалдааны хорио цээрийн шаардлагад нийцсэн мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламжийг байгуулах;						
72	3.4.3.1. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын Үүд боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламжыг байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах;	2019 - 2021			Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах 3313-МОН” төслийн хүрээнд Сэлэнгэ, Дорноговь аймагт шинээр барих мал эмнэлгийн лабораториудын барилгын зураг төслийн баримт бичгийн магадлалын ерөнхий дүгнэлт 2019 оны 7 дугаар сарын 24-ний өдөр бэлэн болов. Лабораториудын барилгын даацын үндсэн хийц нь цутгамал бетон арагт бүтээцтэй, цутгамал төмөр бетон баганан болон нил хавтан суурьтай, цутгамал төмөр бетон хучилттай, 2 давхар байхаар төлөвлөгдсөн байна. Нийт батлагдсан төсөвт өртөг 2.1 сая ам.доллар. Лабораторийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах тендер зарлагдсан. Тендерийн санал хүлээж авах эцсийн хугацаа 2020 оны 3 дугаар сарын 30. Гэрээг 2020 оны 2 дугаар улиралд багтаан байгуулж, 3 дугаар улиралд барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна. Төслийн хүрээнд лабораториудад тоног төхөөрөмж, урвалж бодис, тавилга эд хогшил нийлүүлэгдэх бөгөөд хүснэгтэд үзүүлснээр 2020 оны 2 дугаар улиралд 95 мянган ам.долларын тавилгыг худалдан авч, хүргүүлэхээр тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.Лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодис нийлүүлэх компанийг 2020 оны 2 дугаар улиралд сонгон гэрээ хийнэ. Нийт 1.1 сая ам.долларын өртөг бүхий эд зүйлс хоёр лабораторид хуваарилагдах юм.	0%
73	3.4.3.2. Өмнөговь, Хөвсгөл аймгийн хилийн боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламж байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах;	2019 - 2021			2019 онд Өмнөговь, Хөвсгөл аймгийн хилийн боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламж байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах талаар хийгдсэн ажил байхгүй. 2020 он гарсаар корона вирусын дэгдэлт гарсантай холбогдуулан хилийн боомт бүхий аймгуудын хилийн боомтод ариутгал халдваргүйтгэлийн пункт байгуулах үүргийг Засгийн газраас өгсөнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Гашуун Сухайт боомтод 5 метр өндөр, 4,5 метр өргөн, 8,0 метр урттай түр халдваргүйтгэлийн цэг барьж байна.	40%
74	3.4.3.3. Сүхбаатар, Дорнод аймгийн хилийн боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламж байгуулах,	2019 - 2021			Сүхбаатар, аймаг Дорнод аймгийн хилийн боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламж байгуулаагүй байна. Мөн тэнд шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангагдаагүй байна. Коронавирусын дэгдэлтэй холбогдуулан Дорнод аймгийн Баянхошуу, Сүхбаатар аймгийн Бичигтийн боомтуудад	40%

	шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах;				Петрочайна Дайчин Тамсаг ХХК-ийн хөрөнгөөр халдваргүйтгэлийн түр байгууламж барьж байна. Уг байгууламж /4,5 метр өндөр, 4,5 метр өргөн, 25 метр урт/ сендвичээр барьж байна. Энэ заалтад заагдсан арга хэмжээг МХЕГазар хариуцаж байгаа тул манай төлөвлөлтөд тусгагдаагүй байна.	
3.4.3.б. Мал, амьтны дотоодын шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах;						
75	3.4.3.1. Хулгайн болон албан ёсны зөвшөөрлөөр агнаж байгаа Зэрлэг ан, амьтдыг шинжилгээнд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;	2019 - 2021			Засгийн газрын 2019 оны 12-р сарын 18-ны өдрийн 439-р тогтоолын хүрээнд тусгай зориулалтаар агнах болон барихаар зөвшөөрөл хүсэгчтэй байгуулж буй гэрээнд тухайн харьяалах засаг захиргааны Мал эмнэлгийн байгууллагатай хамтран лабораторийн шинжилгээнд хамруулах тухай хүсэлтийг МЭЭГ-аас БОАЖЯ-д илгээж хамтран ажиллаж байна. ХХААИС-ийн МЭС-тай хамтран зэрлэг гахайд гахайн африкийн мялзан болон бусад халдварт өвчнийг илрүүлэх тандалт, судалгааг гүйцэтгэж байна. БОАЖЯ-наас эрх авч Монгол улсад ан агнасан албан байгууллагад олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгохдоо тухайн зэрлэг амьтнаас заавал дээж авч мал эмнэлгийн лабораторийн шинжилгээнд хамруулсан байх шаардлагыг тавьж ажиллаж байна.	40%
3.4.4. Архангай аймгийн Цахир сумын “Солонготын давааны ам”, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын “Гуртын гүүр”, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын “Таацын голын гүүр”, Төв аймгийн Лүн сумын “Гүүрний ам”-нд байгуулсан мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагааг тогтворжуулж, хүний нөөц, техникийн бэлэн байдлыг бэхжүүлэх;						
76	3.4.4.1. Мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, мал, амьтны шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сайжруулах;	2019 - 2021			Засгийн газрын 240 дүгээр тогтоол "Журам батлах, мал эмнэлгийн хяналтын цэгийн байршил тогтоох тухай"-ын дагуу байгуулагдсан 9 мал эмнэлгийн хяналтын цэгт Мал эмнэлгийн нэгдсэн систем хэрэгжилтийг хангуулахтай холбогдуулан цахим гэрчилгээ уншигч "Samsung tablet" олгосон ба бусад төхөөрөмжөөр бүрэн хангахаар ажиллаж байна. Мал эмнэлгийн цэгүүд халдваргүйтгэлийн автомакс, халдваргүйтгэлийн бодис / Хай-коф, Суперкилл, Хлорын шохой/-ын тодорхой нөөцтэй байна. Мал эмнэлгийн хяналтын цэгүүдээс шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгааг гаргуулан авч хяналтын цэгийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжөөр нэмж хангахаар ажиллаж байна. Архангай аймгийн Цахир сумын Цахирын МЭХЦ, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Таацын голын гүүрний МЭХЦ, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Гуртын гүүрний МЭХЦ, Төв аймгийн Лүн сумын МЭХЦ, Нийслэлийн 5 мал эмнэлгийн хяналтын цэгийн улсын байцаагчдыг өвлийн дүрэмт хувцсаар хангасан. Мал эмнэлгийн гэрчилгээний цахим системийг улсын хэмжээнд 2019 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн улсын хэмжээнд бүрэн нэвтрүүлж, мал эмнэлгийн хяналтын цэгээр нэвтрч байгаа мал, түүхий эдэд хяналт тавьж баталгаажуулсан эсэхийг цахимаар хянан боломж бүрдүүлээд байна. Хяналтын цэгт болон сум, дүүргийн цагдаа цахим системээр гэрчилгээ, баталгаажуулалтыг хянах боломжоор бүрдүүлээд байна. Тайлант хугацаанд хяналтын цэгээр 24649 гэрчилгээнд хяналт хийж, адуу 18103, үхэр 13573, хонь 120475, ямаа 57220, тэмээ 490, гахай 10 хянаж нэвтрүүлээд байна.	100%

77	3.4.4.2. Мал эмнэлгийн хяналтын цэгийн тоног төхөөрөмжөөр хангах	2019 - 2021			Засгийн газрын 240 дүгээр тогтоол "Журам батлах, мал эмнэлгийн хяналтын цэгийн байршил тогтоох тухай"-ын дагуу байгуулагдсан 9 мал эмнэлгийн хяналтын цэгт Мал эмнэлгийн нэдсэн систем хэрэгжилтийг хангуулахтай холбогдуулан цахим гэрчилгээ уншигч "Samsung tablet" олгосон ба мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахаар ажиллаж байна. Архангай аймгийн Цахир сумын Цахирын МЭХЦ, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Таацын голын гүүрний МЭХЦ, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Гуртын гүүрний МЭХЦ, Төв аймгийн Лүн сумын МЭХЦ, Нийслэлийн 5 мал эмнэлгийн хяналтын цэгийн улсын байцаагчдыг өвлийн дүрэмт хувцсаар хангасан.	70%
3.5.1. Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг эхлүүлж тогтмолжуулах;						
78	3.5.1.1. Мэргэжлийн зөвлөлийг харьяа байгууллага болон төрийн бус байгууллагын төлөөллийн оролцуулан байгуулах;	2019 - 2021			Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9, 28.10 дах хэсэгт заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын дэргэд Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/294 дүгээр тушаалаар мал эмнэлгийн төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, боловсрол, үйлдвэрлэлийн байгууллагын төлөөлөл оролцуулан 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 2019 онд нэг удаа, 2020 оны 01 сар нэг удаа хуралдаж шийдвэр гаргаад байна. Мэргэжлийн зөвлөлд ХААИС-ийн Мал эмнэлгийн сургууль, Мал эмнэлгийн хүрээлэн, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, МХЕГ, МҮИС, Монголын үндэсний мал, эмнэлгийн холбоо, Зөвлөх малын эмч нарын холбоо болон МЭЕГ-ын төлөөлөл оролцсон болно.	100%
79	3.5.1.2. Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан батлуулах;	2019 - 2021			Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9, 28.10 дахь хэсгийг үндэслэн ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А-294 дүгээр тушаалаар "Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам"-ыг батлуулан ажиллаж байна. Тус мэргэжлийн зөвлөл нь 2019 онд 1 удаа, 2020 онд 1 удаа тус хуралдаад байна.	100%
80	3.5.1.3. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангах;	2019 - 2021			МЭЕГ-ын дэргэдэх Мэргэжлийн зөвлөлийн анхдугаар хурлыг 2019 оны 12 дугаар сарын 16-нд хийж "Өмнөговь аймгийн мал сүргийг бруцеллээс өвчингүй, тайван байдлыг тогтоон нийтэд мэдээлэх", "Сэлэнгэ, Дархан-Уул аймгийг үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз өвчингүй, тайван байдлыг тогтоон нийтэд мэдээлэх" асуудлыг хэлэлцэж Өмнөговь аймгийг малыг бруцеллээс өвчингүй, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийг үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз өвчингүй болохыг Монгол улсын хэмжээнд тогтоон зарлаж батламж олгохыг Ерөнхий малын эмчид зөвлөснөөр шийдвэрлэж, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул аймагт батламж олгов. Мэргэжлийн зөвлөлийн 2020 оны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гаргасны дагуу 2020 оны эхний хурлыг 2 дугаар сарын 06-ны өдөр хийж "Нийслэлийн нутаг дэвсгэрийн 35000 үхэрт бруцеллээс өвчний тандалт хийж,	70%



					эрүүл, тайван аж ахуй, өрхийг тогтоох ажлын тайлан", "Мал эмнэлгийн арга хэмжээний 2020 оны төлөвлөгөөт дархлаажуулалт, тандалтын төлөвлөгөө", "Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөр тайван байдлыг Олон улсад баталгаажуулах ажлын явцын тайлан" зэргийг хэлэлцэж зөвлөмжүүд гаргалаа.	
3.5.2. Мал эмнэлгийн клиник болон сургалтын загвар аж ахуйг шинээр байгуулж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдлэг, ур чадвартай малын эмч бэлтгэх, давтан сургах;						
81	3.5.2.1. Мал эмнэлгийн клиник болон сургалтын загвар аж ахуй байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх;	2019 - 2021			Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газрын хоорондын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд "Мал эмнэлгийн клиникийн болон сургалтын загвар аж ахуй шинээр байгуулах" таван жилийн хугацаатай төсөл БНСУ-ын 11 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжаар хэрэгжих болов. Барилгын зураг төслийн ажил хийгдэж, 2-р улирлаас барилгын ажил эхлэнэ. МЭЕГ-аас сургалтын танхимыг тохижуулахаар шийдвэрлэв.	70%
82	3.5.2.2. Мал эмнэлгийн клиник болон сургалтын загвар аж ахуйн төвийг түшиглэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 2500 малын эмчид төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтыг жил бүр зохион байгуулах;	2019 - 2021			Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газрын хоорондын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд "Мал эмнэлгийн клиникийн болон сургалтын загвар аж ахуй шинээр байгуулах" таван жилийн хугацаатай төсөл, БНСУ-ын 11 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжаар хэрэгжих юм. Барилгын зураг төслийн ажил хийгдэж, 2-р улирлаас барилгын ажил эхлэнэ. 2020 онд барилга ашиглалтад орж, 2021 онд тоног төхөөрөмжөөр хангагдана. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарын дэлгэрэнгүй 33 үзүүлэлт бүхий судалгааг аймаг, нийслэлээс нараас авч, нэгтгэв. Судалгааг үндэслэн төгсөлтийн дараах сургалтыг шат дараалан зохион байгуулна. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид ажиллаж буй 220 гаруй малын эмчийг Монголын үндэсний мал эмнэлгийн холбоотой хамтран итгэмжлэлийн сургалтад хамрууллаа. Мөн говийн болон төвийн бүсийн мал эмнэлгийн бүсийн зөвлөгөөнийг Өвөрхангай, Дархан-Уул аймагт зохион байгуулж нийт 450 орчим малын эмч мэргэжилтнийг хамрууллаа.	40%
83	3.5.2.3. Малын өвчний тархвар зүйн судалгаа, мал эмнэлгийн арга хэмжээний төлөвлөлтийг хийх сургалтыг зохион байгуулах;	2019 - 2021			Мал эмнэлгийн ерөнхий газраас "Оролцооны эпидемиологи" чиглэлээр Зимбавеби улсад МЭЕГ-аас 1, МЭХ-1, УМЭАЦТЛ-аас 1, Мерси кор монгол улсын байгууллагаас 1 хүн нийт 4 малын эмчийг танилцуулах сургалтад хамруулсан. Сүхбаатар, Хэнтий, Баян-Өлгий, Ховд аймгийн нийт 25 малын эмчийг Оролцооны эпидемиологийн аргаар халдварт өвчнөөс тандан судлах чиглэлээр сургаж сертификатжуулсан. Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчдийг мэргэшүүлэх зорилгоор Мал эмнэлгийн ерөнхий газар Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа "Монгол улсын төв болон баруун бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх" төслийн хүрээнд сумын Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчдэд гоц халдварт өвчний үед дэгдэлтийн судалгаа хийх, био хамгааллыг хэрэгжүүлэх онол, дадлага хосолсон сургалтыг 1 жилийн хугацаанд	100%

					улсын хэмжээнд бүх аймаг, сумдын нийт 359 мэргэжилтнийг хамрууллаа. Сургалтаар гоц халдварт өвчин гарсан тохиолдолд хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөх, Захирамж, шийдвэр гаргах, мэргэжлийн баг ангийг байгуулах, хорио цээр, хязгаарлалтын арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх зэрэг дадлагын ажлыг гүйцэтгэсэн. ArcGIS 10.2 программын сургалтыг Бодлого судлалын төв ТББ-тай хамтран хийсэн сургалтад салбарын нийт 35 мэргэжилтнийг 5 удаагийн давтамжтай хамруулснаар, өвчний тархвар зүйн зураглал хийх чадавх бүрдсэн.	
3.5.3. Мал эмнэлгийн үйлчилгээний анхан шатны түвшинд ажиллах малын эмчийг захиалгаар бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг төрийн бус байгууллага, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамран хэрэгжүүлэх;						
84	3.5.3.1. Мал эмнэлгийн үйлчилгээний жишиг үнийн тарифыг бүсчлэн тогтоох;	Мал	2019		Мал эмнэлгийн ерөнхий газраас 2019 онд Мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг шинээр боловсруулан, батлуулахаар зөвлөх үйлчилгээний тендерийг зарлан Хувийн мал эмнэлгийн дундын хоршоо ТББ шалгаран ажлын даалгаврын дагуу боловсруулан хүлээлгэн өгсөн. Гэвч ХХААХҮЯ, Сангийн яамнаас тус ажлыг дахин боловсруулах чиглэл өгсөний дагуу 2020 онд дахин эдийн засагчдын баг ажиллуулахаар төлөвлөн ажил гүйцэтгэх тендер зарлаад байна. 2020 оны 3 дугаар сард багтаан Сангийн сайд, ХХААХҮ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Ингэхдээ бүсчилсэн байдлаар тогтоохгүйгээр улсын хэмжээнд нэг тариф мөрдөхөөр ажиллаж байна.	40%
85	3.5.3.2. Мал эмнэлгийн үйлчилгээний нэг нэгж, малын эмчид ноогдох малын тоог сум, аймаг, бүс нутгаар нь малын төрөл, нас хүйсийг харгалзан тогтоож, мөрдүүлэх;	Мал	2019		Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хүрээнд Стандартчиллын үндэсний зөвлөлөөр 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолоор MNS 5368:2018 стандартыг батлуулан мөрдөж байна. Тус стандартын 7.1.3-г "Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлэх үед нэг малын эмчийн хариуцах малын тоо хонин толгойд шилжүүлснээр дөчин мянга (40.000)-аас ихгүй байна" гэж заасан байна. Энэхүү шаардлагыг мөрдүүлэх ажлын хүрээнд төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлж байна.	100%
86	3.5.3.3. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх;	Мал	2019 - 2021		15 аймгийн 26 суманд "Ногоон алт" төсөл хэрэгжинэ. Үүнээс 4 суманд 80 сая төгрөг зарцуулагдсан. "Зах зээл ба бэлчээрийн удирдлага" төслөөс Хэнтий аймгийн 18 суманд угаалгын ванн барих төсөл хэрэгжүүлсэн. "Мерси кор" Хэнтий аймгийн Баянхутагт суманд нэг цэгийн үйлчилгээ, нэгдсэн лаборатори байгуулах төсөл хэрэгжүүлсэн. Мөн Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд 1 аж ахуй нэгж 50 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн. НҮБ-ын ХХААБ-аас Шүлхийн өвчний дэгдэлтийн үеэр хэрэгжүүлэх арга хэмжээний үзүүлэх сургуулийг Дундговь аймагт зохион байгуулж, үзүүлэх сургуулийн арга хэмжээнд Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Мал эмнэлгийн газар, Онцгой байдлын газар, Зоонозын өвчин судлалын төв, Төв, Өвөрхангай, Өмнөговь аймгуудын Мал эмнэлгийн газрын холбогдох албан хаагчид хамрагдсан өргөн хэмжээний сургалт болж өндөрлөв.	100%

3.5.4. Лабораторийн ажилтанг мэргэшүүлэх сургалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах;						
87	3.5.4.1. Мал эмнэлгийн лабораториудын боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулах;	2019 - 2021			Монголын үндэсний мал эмнэлгийн холбоотой хамтран малын эмчид үргэлжилсэн болон итгэмжлэл олгох сургалтыг зохион байгуулж, 21 аймаг, нийслэлийн 110 малын их эмч, 120 малын бага эмч нарт таван жилийн хугацаатай малын эмчийн итгэмжлэл олгов. “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл”-ийн хүрээнд “Мах үйлдвэрлэл-Үйлдвэрлэлийн зохистой дадал” сэдэвт 2 өдрийн сургалтыг аймаг, орон нутгийн махны үйлдвэр, хүнсний захын 20 малын эмч нарыг оролцуулан зохион байгуулав. УМЭАЦТЛ-иос нийт эмч, ажилчдад лабораторийн оношилгоо, шинжилгээ, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр 23 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 412 хүнийг хамруулсан. Мөн Булган, Төв, Хэнтий, Баянхонгор аймгийн Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн эмч нарт эмийн үлдэгдлийн сургалтыг “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төсөлтэй хамтран хийв. УМЭАЦТЛ-ийн мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах зорилгоор Австри, Англи, Япон, БНСУ, Франц, тайланд гэх мэт 12 оронд давхардсан тоогоор 30 гаруй мэргэжилтэнг сургалт, семинар, хуралд оролцуулж, мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна.	70%
88	3.5.4.2. Гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн мал эмнэлгийн лабораторийн малын эмч мэргэжилтнийг сургах;	2019 - 2021			2019 онд Мал эмнэлгийн харьяа байгууллага, Аймгуудын Мал эмнэлгийн газар, “Ногоон алт”, “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг дэмжих”, төсөл, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 40 гаруй төрлийн хурал, зөвлөгөөн, сургалт, үзэсгэлэн, семинар зохион байгуулж, 4795 мал эмнэлгийн салбарт ажиллаж байгаа малын эмч, мэргэжилтэн хамрагдсан байна. Гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар болон харьяа байгууллагын нийт 80 гаруй малын эмч, мэргэжилтнүүдийн мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор БНХАУ-ын Шанхай, Жилин мужийн Чанчун, Хөх хотод зохион байгуулагдсан “Малын эмийн олон улсын үзэсгэлэн худалдаа”, “Мал, амьтны халдварт өвчний эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ” олон улсын сургалт, “Хятад-Монголын экспо-3” үзэсгэлэн болон тус улсын эрчимжсэн мал аж ахуйтай танилцах аялалыг санаачлан тус тус амжилттай зохион байгууллаа. Энэ онд бүх сургалтууд давтан зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн боловч, COVID-19 улмаас зарим нэг сургалт цуцлагдах буюу хойшлогдоод байна. • УМЭАЦТЛ нь аймгуудын мал эмнэлгийн газрын лабораторийн шинжлэгч эмч нарт ажлын байрны арга зүй эзэмших сургалт явуулж байгаа. УМЭАЦТЛ-иос нийт лабораторийн эмч, ажилчдад лабораторийн оношилгоо, шинжилгээ, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр 23 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 412 хүнийг хамруулсан байна. Мөн Булган, Төв, Хэнтий, Баянхонгор	100%

					аймгийн Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн эмч нарт эмийн үлдэгдлийн сургалтыг “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төсөлтэй хамтран хийв.	
89	3.5.4.3. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийг түшиглэн хувийн хэвшлийн мал эмнэлгийн нэгжийн малын эмч нарыг сургах;	2019 - 2021			Гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар болон харьяа байгууллага, зах, худалдааны байгууллагын нийт 80 гаруй малын эмч, мэргэжилтнүүдийн мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор БНХАУ-ын Шанхай, Жилин мужийн Чанчун, Хөх хотод зохион байгуулагдсан “Малын эмийн олон улсын үзэсгэлэн худалдаа”, “Мал, амьтны халдварт өвчний эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ” олон улсын сургалт, “Хятад-Монголын экспо-3” үзэсгэлэн болон тус улсын эрчимжсэн мал аж ахуйтай танилцах аялалд тус тус хамруулсан. Монголын үндэсний мал эмнэлгийн холбоотой хамтран малын эмчид үргэлжилсэн болон итгэмжлэл олгох 7 хоногийн сургалтыг зохион байгуулж, 21 аймаг, нийслэлийн 110 малын их эмч, 120 малын бага эмч нарт таван жилийн хугацаатай малын эмчийн итгэмжлэл олгов. Азийн хөгжлийн санхүүжилтээр “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл”-ийн хүрээнд “Мах үйлдвэрлэл-Үйлдвэрлэлийн зохистой дадал” сэдэвт 2 өдрийн сургалтыг аймаг, орон нутгийн мал эмнэлгийн газрын ариун цэвэр, эрүүл ахуйн шинжлэгч эмч, хүнсний худалдааны захын дэргэдэх хувийн хэвшлийн мал эмнэлгийн лабораторийн эмч нарыг оролцуулан зохион байгуулав. УМЭАЦТЛ-иос нийт эмч, ажилчдад лабораторийн оношлогоо, шинжилгээ, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр 23 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 412 хүнийг хамруулсан байна. Мөн Булган, Төв, Хэнтий, Баянхонгор аймгийн мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн эмч нарт эмийн үлдэгдлийн сургалтыг “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төсөлтэй хамтран хийв. Мөн шүлхий, бог малын мялзан, бруцеллёзын тандалт шинжилгээг хийхдээ УМЭАЦТЛ, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын лаборатори хамтран тухай шинжилгээнд хамрагдах сумдын мал эмнэлгийн тасаг, МЭҮН-ийн эмч нарт дээж, сорьц авах, тээвэрлэх, анхан шатны урвал тавих үйл ажиллагаа, арга зүйн талаар сургалтыг тогтмол хийсэн.	100%
90	3.5.4.4. Аймаг, нийслэл дэхь төвлөрсөн худалдааны захын мал эмнэлгийн лабораторийн эмч мэргэжилтнийг сургах;	2019 - 2021			Гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар болон харьяа байгууллага, зах, худалдааны байгууллагын нийт 80 гаруй малын эмч, мэргэжилтнүүдийн мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор БНХАУ-ын Шанхай, Жилин мужийн Чанчун, Хөх хотод зохион байгуулагдсан “Малын эмийн олон улсын үзэсгэлэн худалдаа”, “Мал, амьтны халдварт өвчний эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ” олон улсын сургалт, “Хятад-Монголын экспо-3” үзэсгэлэн болон тус улсын эрчимжсэн мал аж ахуйтай танилцах аялалд тус тус	100%

					хамруулсан. Азийн хөгжлийн санхүүжилтээр “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл”-ийн хүрээнд “Мах үйлдвэрлэл-Үйлдвэрлэлийн зохистой дадал” сэдэвт 2 өдрийн сургалтыг аймаг, орон нутгийн мал эмнэлгийн газрын ариун цэвэр, эрүүл ахуйн шинжлэгч эмч, хүнсний худалдааны захын дэргэдэх хувийн хэвшлийн мал эмнэлгийн лабораторийн эмч нарыг оролцуулан зохион байгуулав. Тайлант хугацаанд 986 хуулийн этгээд, 60863 малчин иргэнд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг танилцуулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 65950 ширхэг мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөн хүргүүлэн ажиллалаа. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт ажиллаж байгаа мал эмнэлгийн тасаг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг танилцуулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 65950 ширхэг мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлж, эрх зүйн акт, мал, амьтны элдэв өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 3349 удаа телевиз, радио, ниймгийн цахим сүлжээний мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийсэн. Мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлжсэн болохыг баталгаажуулах ажлын хүрээнд мал нядалгааны газарт нядлагдаж буй малаас амьсгалын замын эмгэгт дээж хэрхэн авах, бэлтгэх, гээвэрлэх талаар сургалтыг 12 аймгийн мал нядалгааны газар, мах борлуулах цэгийн эмч, ажилчдад хийж, 86 эмчийг сургалтад хамруулсан байна.	
3.2.5. Мал эмнэлгийн лабораторийн ажилтаны цалингийн зэрэглэл, урамшуулалын тогтолцоо бий болгох, тогтвор суурьшилтай ажиллах нийгмийн баталгаагаар хангах асуудлыг боловсруулж холбогдох яам, байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.						
91	3.2.5.1. Мал эмнэлгийн байгууллагын ажилтны цалингийн зэрэглэлийг хууль эрх зүйн хүрээнд тогтоон, холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;	2021			-	Үнэлэх боломжгүй
3.6.1. Мал, амьтны эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх нөхцлийг бүрдүүлэх;						
92	3.6.1.1. Мал, амьтны эрүүл мэндийн даатгалыг нэвтрүүлэх эрх зүй, эдийн засгийн тооцооллыг боловсруулах;	2021			-	Үнэлэх боломжгүй
3.6.2. Малчдад зориулсан мэдээллийг нээлттэй болгох замаар тэдний мэдлэгийг дээшлүүлж, мал эмнэлгийн үйлчилгээнд тавих хэрэглэгчийн хяналтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх;						
93	3.6.2.1. Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа малчдын мал сүргийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх;	2019 - 2021			Монголын үндэсний мал эмнэлгийн холбоотой хамтран говийн болон төвийн бүсийн мал эмнэлгийн бүсийн зөвлөгөөнийг Өвөрхангай, Дархан-Уул аймагт зохион байгуулж нийт 450 орчим малын эмч мэргэжилтнүүдийг хамруулж, орон нутгийн малчдыг мэдээллээр хангах гарын авлага материалаар хангав. Эрүүл мал-Монголын баялаг цуврал нэвтрүүлгийг 14 хоног тутам явуулж, 24 дугаар хүргэсэн. МЭЕГ-ын үйл ажиллагааны тухай “Монголын хөдөө”	100%

					сонингийн 2 дугаар сарын дугаарыг Мал эмнэлгийн ерөнхий газрын Удирдах ажилтны зөвлөгөөнд зориулан д гаргаж, 4 дүгээр сарын дугаарт нийтлэл, мэдээ гаргасан. Шинэ өсөлт хөдөө аж ахуйн сэтгүүл"-тэй хамтран ажиллах гэрээ байгуулан, улирал бүр МЭЕГ-ын мэдээ мэдээлэл, нийтэлж олон нийтэд хүргэсэн байна. Малын эмнэлгийн холбогдолтой нийт 12 ширхэг видео бичлэг /шторк/-ийг хуваарийн дагуу олон нийтэд хүргэж НҮБ-ын ХААБ-аар санхүүжүүлэн Олон нийтийн телевизээр цацсан. Мөн аймаг, нийслэлийн хэмжээнд болсон малчдын зөвлөгөөн, сум, орон нутгийн багийн хуралд аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газраас тогтмол оролцож сургалт, сурталчилгааг хийсэн. Архангай аймагт зохион байгуулсан малын үзлэг, угаалгын үзүүлэх сургалтыг 8 телевиз, байгууллагын цахим болон нүүр хуудас 5 мэдээллийн сайтаар олон нийтэд хүргэсэн. Тайлант хугацаанд 986 хуулийн этгээд, 60863 малчин иргэнд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг танилцуулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 65950 ширхэг мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөн хүргүүлэн ажиллалаа. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт ажиллаж байгаа мал эмнэлгийн тасаг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, мал, амьтны элдэв өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 3349 удаа телевиз, радио, ниймгийн цахим сүлжээний мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийж ажиллав.	
94	3.6.2.2. Мал, амьтны шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан гарч болох халдварт өвчний хор хөнөөл, түүнээс сэргийлэх талаар иргэн хуулийн этгээдийг ухуулга, сурталчилгаа, мэдээллээр хангах;	2019 - 2021			Мал эмнэлгийн ерөнхий газрын даргаар батлуулсан 2019 оны сургалт, семинарын жилийн нэгдсэн төлөвлөгөөний биелэлтийг гаргав. Мал эмнэлгийн харьяа байгууллага, Аймгуудын Мал эмнэлгийн газар, “Ногоон алт”, “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг дэмжих”, төсөл, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 40 гаруй төрлийн хурал, зөвлөгөөн, сургалт, үзэсгэлэн, семинар зохион байгуулж, 6795 мал эмнэлгийн салбарт ажиллаж байгаа малын эмч, мэргэжилтэн, малчид мал бүхий иргэд хамрагдсан байна. Тайлант хугацаанд 986 хуулийн этгээд, 60863 малчин иргэнд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг танилцуулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 65950 ширхэг мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөн хүргүүлэн ажиллалаа. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт ажиллаж байгаа мал эмнэлгийн тасаг Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, мал, амьтны элдэв өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 3349 удаа телевиз, радио, ниймгийн цахим сүлжээний мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийж ажиллав. Байнгын ажиллгаатай 6 постоор мал тээвэрлэж, тууварлан нэвтэрч буй малчид, иргэд, ААН-ийн хүмүүст малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл хийх, мал тээвэрлэх, тууварлах үеийн шаардлага,	100%

					гэрчилгээний талаар тогтмол мэдээлэл өгч, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцон ажилласан. “Монгол малчин” сэтгүүлтэй хамтран сар бүрийн дугааруудад мэдээлэл, ярилцлага нийтлүүлж, 4 дүгээр сарын дугаарт Мал эмнэлгийн гэрчилгээний нэгдсэн системийн Завхан аймгийн 20 суманд жишиг, 11 дүгээр сарын дугаарыг Малын эмч нарын анхдугаар их хуралд зориулан тусгай дугаараар олон нийтэд сурталчлан хүргэж ажилласан.	
95	3.6.2.3. Малчид, мал бүхий иргэн, хуулийн этгээдэд мал эмнэлгийн хууль, дүрэм журмыг сурталчлан, таниулах;	2019 - 2021			Монгол Улсын Их Хурлаар 2017 он батлагдсан “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын болон шилжилтийн үеийн бэлтгэлийг хангах үйл ажиллагааг төлөвлөх, дагалдан гарах хууль, эрх зүйн актыг боловсруулах, олон нийтэд сурталчилан таниулах үүрэг бүхий Ажлын хэсгийг 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр А-174 дугаар тушаалаар байгуулж, бэлтгэл ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А-07 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Малын генетик нөөцийн тухай болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг 21 аймаг, нийслэлийн 332 сум, 6 дүүрэгт сурталчилан таниулах, гарын авлага материалаар хангах, орон нутагт хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг шат дараатай зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, мал аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл бүхий 3000 орчим хүнийг хамруулж сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулав. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг дагалдан гарсан мал, амьтны өвчинтэй тэмцэх заавруудын эмхэтгэлийг орон нутагт хүргүүлээд байна. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газраас 2018, 2019 онд малчдын зөвлөгөөн, бусад хурал зөвлөгөөнд танилцуулсан. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Мал эмнэлгийн ерөнхий газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор МҮОНРТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж, Эрүүл мал-Монголын баялаг цуврал нэвтрүүлэг 14 хоног тутам цацаж, 24 дугаар хүргэсэн. Үйл явдлын мэдээ мэдээллийг цаг тухай бүрт олон нийтийн цахим сүлжээ болон байгууллагын цахим хуудас, пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. Тайлант хугацаанд 986 хуулийн этгээд, 60863 малчинд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг танилцуулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 65950 ширхэг мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлсэн.	100%
3.6.3. Мал, амьтны өвчлөл, мал эмнэлгийн үйлчилгээний ач холбогдлыг олон нийтэд таниулан сургалт, сурталчилгаа зохион байгуулах.						
96	3.6.3.1. Гоц халдварт өвчний чиглэлээр;	2019 - 2021			НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 5 төрлийн анимэйшн, дээж бэлтгэх, илтгээхэд зориулсан сургалтыг 5 төрлийн	100%

					видео хичээлийн бэлтгэн цахим сайт (you tube), болон МЭЕГ-ын вэб сайт, мал эмнэлгийн лабораторийн нэгдсэн систем зэрэгт байршуулж салбарын мэргэжилтнүүдэд хүргүүлдэд байна.	
97	3.6.3.2. Малаас хүнд дамжин халдварладаг өвчний чиглэлээр;	2019 - 2021			Малаас хүнд дамжин халдварладаг зооноз өвчинтэй тэмцэх талаар ЭМЯ, ХХААХҮЯ, МЭЕГ-ын хамтарсан хуралдааныг 2018 онд 2 удаа, 2019 онд 1 удаа хийж ажиллав. Мөн малчид, иргэдэд зооноз өвчнөөс хэрхэн сэргийлэх, хор хохирлын талаар гарын авлалыг боом, галзуу, бруцеллэз зэрэг өвчнөөр хийн орон нутгийн Мал эмнэлгийн байгууллагаар дамжуулан тараав. Мөн Монголын үндэсний телевизтэй гэрээ хийн "Эрүүл мал Монголын баялаг" нэвтрүүлэг хийн дээрх өвчнүүдтэй, сэргийлэх арга хэмжээний талаар 2 нэвтрүүлэг хийв. Мөн Дэлхийн зооноз өвчинтэй тэмцэх өдөр, Дэлхийн галзуу өвчинтэй тэмцэх өдрийн хүрээнд ЗӨСҮТ-тэй хамтран нэвтрүүлэг хийв.	100%
98	3.6.3.3. Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний чиглэлээр;	2019 - 2021			ДМАЭМБ-аас бэлтгэн гаргасан Гахайн африкийн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий зурагт хуудсыг орчуулан ДМАЭМБ-аас албан ёсны зөвшөөрлийг авч хэвлүүлэх ажил хийгдэж байна. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Мал эмнэлгийн ерөнхий газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор МҮОНРТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулан Эрүүл мал-Монголын баялаг цуврал нэвтрүүлэг бэлтгэж, 14 хоног тутам цацаж, 24 дугаар хүргэсэн. Малын эмнэлгийн холбогдолтой болон шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 5 төрлийн анимэйшн, дээж бэлтгэх, илгээхэд зориулсан сургалтын 5 төрлийн видео хичээлийн бэлтгэн, нийт 12 ширхэг видео бичлэг /шторк/- халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гэрчилгээний нэгдсэн систем, мал амьтны шилжилт хөдөлгөөн гэх мэт/ хуваарийн дагуу олон нийтэд хүргэж НҮБ-ынХ ХААБ-аар санхүүжүүлэн Олон нийтийн телевизээр шторкоо хүргэж, цахим орчинд байршуулан ажилласан.	100%
99	3.6.3.4. Шимэгчтэх өвчний чиглэлээр;	2019 - 2021			Мал, амьтны шимэгчтэх өвчний заавруудыг боловсруулан орон нутагт хүргүүлдэд байна. ХХААХҮЯ, Монголын арьс, ширний холбоо ТББ, бусад төлөөллийг оролцуулан 2019 оны 5 дугаар сард хурал зохион байгуулж, цаашид хэрэгжүүлэх ажлыг хэлэлцсэн. Мөн Мал эмнэлгийн ерөнхий газраас Хүлэг студи ХХК-иар Малын шимэгчтэх өвчинтэй тэмцэхийн ач холбогдол, хэрхэн тэмцэх талаар нэвтрүүлэг бэлтгэн ТВ болон цахим орчинд байршуулан ажилалсан. "Эрүүл мал- Монголын баялаг " нэвтрүүлгийн 1 удаагийн дугаараар шимэгчтэх өвчний хор, хирол, хэрхэн тэмцэх, үр дүнгийн талаар 25 минутын нэвтрүүлгийг хийж МҮОНТ-ээр нэвтрүүлж, цахим орчинд байршуулсан. ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан, УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн нарын санаачлагаар Архангай аймгийн Булган суманд мал угаах зөөврийн болон суурин үйл ажиллагааг таниулсан сургалтыг 2019 оны 7 дугаар сард хийж, малчид, иргэдийн төлөөллийг оролцуулж, Монгол улсын хэмжээнд нэвтрүүлэг бэлтгэн цацсан.	100%